

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ  
“ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН “БАЯНХӨНДИЙ АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ  
АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-021444/  
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2718243/

Хянасан:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны  
Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын  
ахлах шинжээч ...../Ц.Жаргалнэмэх/

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал  
жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн:...../Б.Наранбаатар/

Биелэлтийг тайлагнасан:

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал:...../А.Билгүүн/

Байгаль орчны ахлах ажилтан:..... /Э.Өнөрзаяа/

2024 он

## ГАРЧИГ

|   |    |
|---|----|
| БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....   | 6  |
| 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....  | 6  |
| 1.1.3. Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг.....  | 6  |
| 1.2. Төслийн зорилго.....   | 7  |
| 1.3. Хүчин чадал, хэрэгжих хугцаа.....  | 7  |
| 1.4. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт .....  | 8  |
| 1.5. Уурхайн ажлын горим .....  | 8  |
| 1.6. Уурхайн ажилчдын хотхон.....   | 8  |
| 1.7. Цахилгаан хангамж .....  | 9  |
| 1.8. Усан хангамж .....   | 9  |
| 1.8.1. Ажилчдын хотхоны усны хэрэгцээ (унд, ахуй) .....   | 12 |
| 1.8.2. Замын тоос дарах усалгаа .....   | 12 |
| 1.8.3. Барилга угсралтын усны хэрэглээ.....   | 14 |
| 1.8.4. Хайгуулын өрөмдлөгийн усны хэрэглээ.....   | 14 |
| 1.8.5. Байгалийн ургамал үржүүлгийн газар .....   | 14 |
| 1.9. Тээвэрлэлт .....   | 15 |
| 1.9.1. Ачаа тээвэрлэлт .....  | 16 |
| 1.9.2. Дотоод тээвэрлэлт .....  | 16 |
| 1.10. Уурхайн дулаан хангамж .....  | 17 |
| БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... | 18 |
| 2.1. Физик газарзүй.....  | 18 |
| 2.2. Уур амьсгал .....  | 18 |
| 2.3. Гадаргын ус .....  | 18 |
| 2.4. Газрын доорх ус .....  | 18 |
| 2.5. Хөрсөн бүрхэвч.....  | 19 |
| 2.6. Ургамалан нөмрөг .....   | 19 |
| 2.7. Амьтны аймаг .....   | 20 |
| 2.8. Нийгэм - Эдийн засаг.....  | 20 |
| БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....  | 21 |
| БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....                   | 24 |
| 4.1. Зорилго, зорилт .....  | 24 |
| 4.2. Баримтлах зарчим.....  | 24 |
| 4.3. Хамрах хүрээ .....   | 24 |
| 4.4. Байгаль орчны үнэлгээ.....   | 28 |
| 4.5. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй .....         | 28 |
| 4.6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....                                      | 30 |
| 4.6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....                                     | 40 |
| 4.6.2. Нийгэм, эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл .....   | 43 |
| 4.7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт .....  | 44 |
| 4.8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....                  | 50 |
| 4.8.1. Биотехнологийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал.....   | 50 |

|   |    |
|---|----|
| 4.8.2. Дүйцүүлэн хамгааллын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд .....   | 51 |
| 4.9. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт .....   | 54 |
| 4.10. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт<br>54                           |    |
| 4.11. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....                                      | 55 |
| 4.12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....  | 57 |
| 4.13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....   | 62 |
| 4.14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....   | 68 |
| 4.15. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ.....                                      | 74 |
| 4.16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....  | 74 |
| 4.17. БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах<br>төлөвлөгөөний биелэлт, 2024 он ..... | 75 |
| БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ .....  | 78 |
| БҮЛЭГ 6. АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....   | 80 |
| БҮЛЭГ 7. ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ .....  | 81 |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга .....  | 6  |
| Хүснэгт 2. Хөндий (MV-021444) тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбицол .....  | 7  |
| Хүснэгт 3. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд .....                                      | 8  |
| Хүснэгт 4. Хүрэнцав, Босгын сайр орчмын талбайн газрын доорх усны ордуудын ашиглалтын нөөцийн үйлдвэрлэлийн зэргийн ангилал ..... | 10 |
| Хүснэгт 5. Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл .....                               | 21 |
| Хүснэгт 6. Барилгын ажлын гүйцэтгэл .....   | 24 |
| Хүснэгт 7. Ус ашиглах зөвшөөрөл .....   | 27 |
| Хүснэгт 8. Байгаль орчны үнэлгээ .....  | 28 |
| Хүснэгт 9. БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2024 он .....  | 28 |
| Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....   | 30 |
| Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт .....   | 45 |
| Хүснэгт 12. Тариалалтын мэдээ, 2024 оны .....   | 49 |
| Хүснэгт 13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....                             | 53 |
| Хүснэгт 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт .....  | 54 |
| Хүснэгт 15. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....                                     | 55 |
| Хүснэгт 16. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....  | 56 |
| Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....   | 57 |
| Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....   | 65 |
| Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....   | 69 |
| Хүснэгт 20. Хяналт шалгалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт .....  | 74 |
| Хүснэгт 21. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт .....                                   | 74 |
| Хүснэгт 22. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....                           | 76 |
| Хүснэгт 23. БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2024 он .....   | 79 |



## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| Зураг 1. Хөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг .....                | 6  |
| Зураг 2. Баянхөндий түр хээрийн анги .....                                      | 9  |
| Зураг 3. Ус хангамжийн худгуудын байршил .....                                  | 11 |
| Зураг 4. Уртын гол /ВКW-30/ худгийн усны тоолуур .....                          | 12 |
| Зураг 5. Замын усалгаа .....  | 13 |
| Зураг 6. Байгалийн ургамал үржүүлгийн газар .....                               | 14 |
| Зураг 7. “Замын чиглэл тогтоох тухай” захирамж .....                            | 15 |
| Зураг 8. Баянхөндий төслийн дотоод зам .....                                    | 16 |
| Зураг 9. Барилга угсралтын үйл явц .....  | 40 |
| Зураг 10. Үндсэн кэмийн барилгын үйл явц .....                                  | 40 |
| Зураг 11. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн мэдээллийн сан .....          | 41 |
| Зураг 12. Байгаль хамгаалах сургалт зохион байгуулж байгаа байдал .....         | 42 |
| Зураг 13. Төслийн талбай доторх замын маршрут .....                             | 43 |
| Зураг 14. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэв .....                          | 44 |
| Зураг 15. Шимт хөрсний овоолго .....  | 48 |
| Зураг 16. Шимт хөрсний овоолго дээр тарилт хийж байгаа байдал .....             | 48 |
| Зураг 17. Үрээр тарьсан заг, жигдний ургалтын байдал .....                      | 49 |
| Зураг 18. Зам дагуу шилжүүлэн тарилт хийсэн байдал .....                        | 49 |
| Зураг 19. Мазаалайн тэжээлийн сав .....   | 50 |
| Зураг 20. Өвс, тэжээл тавьж байгаа байдал .....                                 | 51 |
| Зураг 21. Нутгийн иргэдтэй хамтран тарьсан модны ургалтын байдал .....          | 52 |
| Зураг 22. Ламын тооройн хөв .....   | 52 |
| Зураг 23. Кэмийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт .....                                | 54 |
| Зураг 24. Гамшгийн үеийн бэлэн байдлын сургуулилалт .....                       | 61 |
| Зураг 25. Мэдээллийн самбарууд, анхны тусламжийн хайрцаг .....                  | 62 |
| Зураг 26. Хуванцрыг пресслэсэн байдал .....                                     | 63 |
| Зураг 27. Бүх нийтийн цэвэрлэгээ хийх талбайн хуваарь .....                     | 63 |
| Зураг 28. Хог хаягдлаар бүтээл хийх уралдаан .....                              | 64 |
| Зураг 29. Төрийн албан хаагч нар, иргэд төслийн талбайтай танилцсан тухай ..... | 76 |

## ОРШИЛ

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутагт “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж, дэд бүтэц, боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажил үргэлжлэн явагдаж байна. Тус компани нь байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн туршлага, менежментийг нэвтрүүлж олон нийтэд нээлттэй, хариуцлагатай уул уурхайн жишиг төсөл болох зорилго тавин ажиллаж байна.

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, журамд заасан хугацаанд буюу 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр БОАЖЯ-нд хүргүүлсэн. БОМТ-г 2024 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хянаж, 02 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1 дэх хэсэгт заасны дагуу Усны газрын 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 31 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай ус ашиглах гэрээг байгуулсан.

Баянхөндий төслийн талбайд 2024 онд төлөвлөсөн 32 барилгуудыг барих ажил үргэлжлэн явагдаж байгаагийн зэрэгцээ хайгуулын ажил үргэлжлэн 1810 т.м өрөмдлөг, 937.8 м<sup>3</sup> суваг малталтын ажил хийсэн.

Бид байгалийн ургамал үржүүлгийн газрын услалтын системийг өргөтгөн 54176 ш үрсэлгээ бэлдсэн.

Энэхүү “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”-д байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээр сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний зэргийг тогтоосны дагуу “Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар 2024 онд авч хэрэгжүүлсэн ажил, зарцуулсан хөрөнгийн хэмжээг тусгав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 147.97 сая төгрөг төлөвлөж 506.3 сая төгрөг, “Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөө”-нд 65 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 156.62 сая төгрөгийг зарцуулсан.

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Эрдэнэ Монгол” ХХК нь Канад улсын Торонтогийн Хөрөнгийн Бирж (тэмдэг: ERD), Монгол улсын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй (тэмдэг: ERDN) Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн компани, Хонг Конгийн Хөрөнгийн Бирж (тэмдэг: 975) бүртгэлтэй Монголиан Майнинг Корпорэйшн ХХК хамтарсан хөрөнгө оруулалттай, MV-02144 дугаартай “Хөндий” тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

### Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

|                                  |   |
|----------------------------------|---|
| <b>1.1.1. Төслийн нэр</b>        | “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төсөл   |
| <b>1.1.2. Төсөл хэрэгжүүлэгч</b> | Байгууллагын нэр: “Эрдэнэ Монгол” ХХК<br>Улсын бүртгэлийн дугар: 9019005124<br>Регистрийн дугаар: 2718243<br>Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД 8-р хороо, Сентрал таур, 16 давхар<br>Утас: +976 77118534 |

### 1.1.3. Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшдэг MV-02144 дугаартай “Хөндий” тусгай зөвшөөрлийн талбай нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутагт байрладаг. “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбай нь Улаанбаатар хотоос 1000 км, Баянхонгор аймгийн төв Баянхонгор хотоос баруун урагш 350 км, Шинэжинст сумын төвөөс баруун урагш 85 км зайтай.



Зураг 1. хөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг

Ашигт малтмалын газрын ГУУКХ-ийн даргын шийдвэрээр “Эрдэнэ Монгол” ХХК-д Хөндий нэртэй газар хайгуулын XV-015569 тусгай зөвшөөрөлтэй 19936.34 га талбайг 2010 онд олгож, хайгуулын ажлын явцад “Эрдэнэ Монгол” ХХК-ийн хүсэлтээр 2014 онд 15422.01 га талбайг буцаан, 4514.33 га талбайд хайгуулын ажлыг үргэлжлүүлэн хийж, 2308.62га талбайд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон ба үлдсэн 2205.71га талбайг буцаан өгсөн.

Хөндий талбайд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнг 2019 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж нөөцийг батлуулсан бөгөөд “Эрдэнэ Монгол” ХХК-д АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр 2019 оны 08 дугаар сарын 05-нд ашигт малтмал ашиглах MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий 2308.62 га талбайг 30 жилийн хугацаатай олгосон.

## Хүснэгт 2. Хөндий (MV-021444) тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбицол

| Эргэлтийн цэг | Уртраг         | Өргөрөг        |
|---------------|----------------|----------------|
| 1             | 98° 48' 40.00" | 43° 53' 50.00" |
| 2             | 98° 47' 18.81" | 43° 53' 50.00" |
| 3             | 98° 46' 33.93" | 43° 57' 36.11" |
| 4             | 98° 50' 00.34" | 43° 57' 36.11" |
| 5             | 98° 50' 00.34" | 43° 55' 30.00" |
| 6             | 98° 48' 40.00" | 43° 55' 30.00" |

### 1.2. Төслийн зорилго

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших "Баянхөндий" алтны үндсэн ордыг орчин үеийн шинэ техник, технологид суурилан Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу эдийн засгийн өндөр үр ашигтайгаар ашиглах, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

### 1.3. Хүчин чадал, хэрэгжих хугацаа

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт Хөндий нэртэй газар орших Баянхөндийн алтны үндсэн ордоос 5 жилийн хугацаанд гадаад овоолготой, ил аргаар алт олборлоно.

Ашиглалтын хугацаанд 40.05 сая тонн хөрс хуулалтын ажил хийж, хаягдал бохирдол тооцоогүй дүнгээр нийт 2.26 сая тонн исэлдсэн хүдэр, 0.51 сая тонн анхдагч хүдэр, 5.32 сая тонн ядуу хүдэр (ядуу хүдэр гэж өнөөгийн эдийн засгийн нөхцөлд үр ашиггүй нөөцийг нэрлэсэн) олборлоно. Баяжуулах үйлдвэр нь жилд 600 мян.тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд нийт 10.3 тн алт ялган авахаар төлөвлөсөн.

#### 1.4. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт

Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах хугацаанд ил уурхай, гадаад овоолгууд, баяжуулах үйлдвэр, уурхайн ажилчдын хотхон болон засвар, үйлчилгээний барилга байгууламжууд баригдна. Эдгээр барилга байгууламжуудыг 117.44 га талбайд барихаар зураг төслийг боловсруулсан.

**Хүснэгт 3. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд**

| №           | Барилга байгууламж           | Талбай, га    | Эзлэхүүн, мян.м <sup>3</sup> |
|-------------|------------------------------|---------------|------------------------------|
| 1           | Авто зам                     | 20.48         | -                            |
| 2           | Авто машины зогсоол          | 2.52          | -                            |
| 3           | Баяжуулах үйлдвэр            | 2.94          | -                            |
| 4           | Дулаан хангамжийн байгууламж | 0.50          | -                            |
| 5           | Засварын газар               | 0.22          | -                            |
| 6           | Ил уурхай                    | 30.16         | -                            |
| 7           | Тэсрэх бодисын агуулах       | 0.13          | -                            |
| 8           | Уурхайн ажилчдын хотхон      | 1.40          | -                            |
| 9           | Уурхайн оффис                | 0.19          | -                            |
| 10          | Халаалтын зуух               | 0.50          | -                            |
| 11          | Хаягдлын нэгдсэн байгууламж  | 48.02         | 19,500.0                     |
| 12          | Хаягдлын талбай              | 5.04          | -                            |
| 13          | Хүдрийн овоолгын талбай      | 2.03          | -                            |
| 14          | Шатахуун түгээх станц        | 0.39          | -                            |
| 15          | Шимт хөрсний овоолго         | 2.92          | -                            |
| <b>Нийт</b> |                              | <b>117.44</b> | <b>19,500.0</b>              |

#### 1.5. Уурхайн ажлын горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилд 350 хоног ажиллаж, 15 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар ТЭЗҮ-д тусгагдсан. Уурхай нь хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Төслийн барилга угсралтын үйл ажиллагаа 2023 оны 7 дугаар сараас эхэлж өдрийн ээлж 12 цагаар ажиллаж байна.

#### 1.6. Уурхайн ажилчдын хотхон

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий хээрийн анги нь Баянхонгор аймгийн Шинэжинет сумын Уртын гол 2 дугаар багийн нутаг дэвсгэрт хоногт дунджаар 70 хүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Барилга угсралт, ачаа тээврийн үйл ажиллагааг М-Си-Эс Проперти ХХК, хаягдлын нэгдсэн байгууламж барих ажлыг Гложекс консалтинг ХХК, тэсрэх бодисын агуулахыг Стокблест ХХК, хээрийн ангийн катеринг үйлчилгээг Монруд ХХК, өрөмдлөгийн ажлыг Фалкон дриллинг Монголиа, Элгэн ХХК-ууд, харуул хамгаалалтын үйлчилгээг М-Армор ХХК, тээврийн замыг сайжруулах ажлыг Өсөх урам ХХК, гидрогеологийн судалгааны ажлыг Охь ус ХХК гэрээгээр гүйцэтгэдэг.





**Зураг 2. Баянхөндий түр хээрийн анги**

### **1.7. Цахилгаан хангамж**

Баянхөндий төслийн талбай орчмын нутагт дэд бүтэц сул хөгжсөн. Хамгийн ойрын суурин газар болох Шинэжинст сумын төв нь төвийн эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдсон хэдий ч эрчим хүчний хүрэлцээ муу байдаг тул Баянхөндий хээрийн ангийн цахилгааны эх үүсвэрийг Caterpillar үйлдвэрийн DE450E0 загварын ISO8528 стандартын шаардлага хангасан дизель генератороор хангадаг.

Төслийг цахилгаанаар хангах Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас Баянхонгор аймгийн Шинэжинст сум хүртэл 110кВ-ын 242 км цахилгаан дамжуулах агаарын шугам 110/11 кВ-ын 2\*16 МВА чадалтай Баянхөндий дэд станц, 2\*2750 кВА чадалтай дизель генератор, 7.7 км урттай 11 вК-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг М-Си-Эс Интернэйшнал ХХК гүйцэтгэж байна.

### **1.8. Усан хангамж**

Уурхайн усны хэрэглээг хангах зорилгоор 2019 онд гүйцэтгэсэн газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны үр дүнд Хүрэнцавын талбай, Хүрэнцавын зүүн талбай, Шинэ кемпийн талбай гэсэн усжилт өндөртэй 3 талбайг ялгаж газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр 10 л/с хэмжээгээр тогтоосон. Усны газрын


2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 158 тоот дүгнэлтэд төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах  $861.58\text{м}^3/\text{хоног}$  усыг, нийт 10 л/сек буюу  $950.4\text{ м}^3/\text{хоног}$  газрын доорх усны орд болон шүүрлийн усыг хуримтлуулан хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэж дүгнэсэн.

Газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлаар 6 цооног өрөмдөж сорилын шавхалт явуулж, уст үеийн параметруудийг тодорхойлон тухайн цооногт урт хугацааны ашиглалтын үеийн ундаргын нөөцийн тооцоог хийж, усны нөөцийг батлуулсан.

**Хүснэгт 4. Хүрэнцав, Босгын сайр орчмын талбайн газрын доорх усны ордуудын ашиглалтын нөөцийн үйлдвэрлэлийн зэргийн ангилал**

| №                             | Хайгуул-ашиглалтын дугаар, худгийн нэр | цооногийн | Газрын доорх усны ашиглалтын боломжит нөөцийн үйлдвэрлэлийн зэрэг |                           |
|-------------------------------|--|-----------|---|---------------------------|
|                               |  |           | л/с   | $\text{м}^3/\text{хоног}$ |
| <b>Хүрэнцавын талбай</b>      |  |           |   |                           |
| 1.                            | W-1                                    |           | 3.5   | 302.4                     |
| 2.                            | W-2                                    |           | 1.7   | 146.88                    |
| 3.                            | W-3                                    |           | 3.9   | 336.96                    |
| 4.                            | Дүн                                    |           | 9.1   | 786.24                    |
| <b>Хүрэнцавын зүүн талбай</b> |  |           |   |                           |
| 1.                            | W-4                                    |           | 0.9   | 77.76                     |
| 2.                            | Дүн                                    |           | 0.9   | 77.76                     |
| 3.                            | Үйлдвэрийн хэрэгцээнд                  |           | 10.0  | 864.0                     |
| <b>Шинэ кемпийн талбай</b>    |  |           |   |                           |
| 1.                            | W-5                                    |           | 0.75  | 64.8                      |
| 2.                            | W-6                                    |           | 0.25  | 21.6                      |
| 3.                            | Дүн                                    |           | 1.0   | 86.4                      |
| 4.                            | Ахуйн хэрэгцээнд                       |           | 1.0   | 86.4                      |
| <b>НИЙТ ДҮН</b>               |  |           | <b>11.0</b>   | <b>-</b>                  |

Компани нь дээрх нөөцийг тогтоох судалгааны үед хийгдсэн шавхалт туршилтын хугацаа бага байсан тул дахин урт хугацаагаар шавхалт туршилт, технологийн ус хангамжийг нэмэгдүүлэх зориулалттай газрын доорх усны эрэл – хайгуулын судалгааны ажлыг Усны газраар 2023 оны 03 дугаар сарын 23–нд батлуулан хээрийн ажлыг гүйцэтгэсэн. Уг ажлын тайлан Усны нөөцийн зөвлөлийн хурлаар 2024 оны 5 сард хэлэлцэгдэж нэмэлтээр гадаргын усны судалгааг хийж ирүүлэх даалгаврын дагуу судалгааг гүйцэтгэн боловсруулж Усны нөөцийн зөвлөлд 08 дугаар сард хүргүүлсэн ба одоогоор нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.



Зураг 3. Ус хангамжийн худгуудын байршил

Төслийн үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн зориулалтаар ус авч ашигладаг Уртын гол /BKW-21/ худагт 2023 оны 08 дугаар сарын 06-нд LGX 40 мм голчтой, хүйтэн усны, үйлдвэрийн ус авдаг Уртын гол /BKW-30/ LGX 40 мм голчтой, хүйтэн усны, Уртын гол /BKW-44/ LGX 40мм голчтой, хүйтэн усны, хээрийн ангийн ахуйн хэрэглээ болон ургамал үржүүлгийн зориулалтаар ус авдаг Шинэ кэмийн худагт 2023 оны 06 дугаар сарын 20-нд LGX 32 мм голчтой, хүйтэн усны баталгаат тоолуурыг суурилуулж, Баянхонгор аймгийн





Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар лац ломбо тавиулж хэрэглэж байна.

#### Зураг 4. Ургын гол /ВКВ-30/ худгийн усны тоолуур

##### 1.8.1. Ажилчдын хотхоны усны хэрэгцээ (унд, ахуй)

Төсөл хөгжүүлэлтийн үйл явцтай холбоотойгоор хоногт дунджаар Баянхөндий хээрийн анги 70 ажилтан, ерөнхий гүйцэтгэгчийн хээрийн анги 381 ажилтантай ажиллаж байна. Ажилчдын хотхоны ахуйн усны хэрэгцээнд 2024 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар 8007 м<sup>3</sup> ус хэрэглэсэн.

##### 1.8.2. Замын тоос дарах усалгаа

Агаар дахь тоосонцрын хэмжээг стандартаас давуулахгүй байх зорилгоор зам, талбайн усалгааг өдөр бүр гүйцэтгэж байгаа ба Шинэжинст сумаас төслийн талбай хүртэлх тээврийн замын усалгааг орон нутгийн аж ахуйн нэгжүүд, иргэдтэй гэрээ байгуулан гүйцэтгэж байна.





Хөндий талбайд барилга угсралтын ажил үргэлжлэн явагдаж байна, 10 дугаар сарын 20-ны байдлаар 2023 онд эхэлсэн болон энэ онд шинээр эхэлсэн барилгууд үргэлжлэн баригдаж, тэдгээрийг барихад шаардагдах буцаан дүүргэлтийн материал услахад зарцуулсан усыг оруулан тооцоход нийт 6791 м<sup>3</sup> ус хэрэглэсэн.

### **1.8.3. Барилга угсралтын усны хэрэглээ**

Хөндий талбайд барилга угсралтын ажил үргэлжлэн явагдаж байна, 10 дугаар сарын 20-ны байдлаар 2023 онд эхэлсэн болон энэ онд шинээр эхэлсэн барилгууд үргэлжлэн баригдаж, тэдгээрийг барихад шаардагдах буцаан дүүргэлтийн материал услахад зарцуулсан усыг оруулан тооцоход нийт 6791 м<sup>3</sup> ус хэрэглэсэн.

### **1.8.4. Хайгуулын өрөмдлөгийн усны хэрэглээ**

Хөндий талбайд хайгуулын өрөмдлөгийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж 10 дугаар сарын 16-ны байдлаар 2453.9 т.м өрөмдлөг, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажлын хүрээнд 120 т.м өрөмдлөг, 32 м<sup>3</sup> уулын малталтын ажлыг гүйцэтгэж, өрөмдлөгт хэрэглэж байгаа усыг хэмнэлттэй хэрэглэх зорилгоор эргүүлэн ашигладаг, нийт 640 м<sup>3</sup> ус хэрэглэсэн.

### **1.8.5. Байгалийн ургамал үржүүлгийн газар**


Байгалийн ургамал үржүүлгийн газрыг 2022 онд 2 га талбайд байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20 тн багтаамжтай 2 контайнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч хийсэн ба 5 тн багтаамжтай нөөцийн сав 5 ш байршуулж, 2023 онд усалгааны систем суурилуулсан. Үрээр заг, хайлаас, шар хотир, хармаг, агч, жигд, шар хуайс, бүйлс, тоорой мөчрөөр сухай нийт 72158 ш үрсэлгээг тарьж, 54176 ш суулгацыг ургуулсан. Өмнөх онд тариалсан үрсэлгээнээс 840 ш суулгацыг ургамал үржүүлгийн талбайд шилжүүлэн суулгаж, Шинэжинст суманд гэрээ байгуулан мод тарих ажлыг гүйцэтгэж байгаа иргэдэд 5850 ш суулгацыг шилжүүлэн өгсөн. Ургамал үржүүлгийн талбай дахь усалгаанд 4065 м<sup>3</sup> ус хэрэглэсэн.



**Зураг 6. Байгалийн ургамал үржүүлгийн газар**

## 1.9. Тээвэрлэлт

Улаанбаатар хотоос төслийн талбай хооронд төслийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа хүн тээвэр (977 км), хүнс тээвэр (947 км), ачаа тээвэр (975 км) гэсэн 3 маршрутаар хийгддэг. Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Замын чиглэл тогтоох тухай” А/396 дугаар захирамжаар батлагдсан чиглэлээр тээвэрлэлтийг гүйцэтгэж байна.




Зураг 7. “Замын чиглэл тогтоох тухай” захирамж

### 1.9.1. Ачаа тээвэрлэлт

Олон салаа зам гаргах, замыг өргөсгөх, тоосжилтоос сэргийлэх зорилгоор ачаа тээврийн батлагдсан дагуу шаардлагатай цэгүүдэд замын тэмдэг тэмдэглэгээг байршуулахын зэрэгцээ жолооч нарт тогтоосон маршрутын дагуу тээвэрлэлт хийхийг тогтмол анхааруулж, тогтоосон маршрутаас өөр замаар зорчсон тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ аван ажилладаг.

### 1.9.2. Дотоод тээвэрлэлт

Олон салаа зам гаргах, замыг өргөсгөх, тоосжилтоос сэргийлэн төслийн талбай дотор доорх маршрутыг мөрдөн хөдөлгөөнд оролцож байна.



Зураг 8. Баянхөндий төслийн дотоод зам

### **1.10. Уурхайн дулаан хангамж**

Төслийн талбай дахь оффис, амралтын танхим, гал тогоо, ангор, бие засах газар, анхны тусламжийн төв, ерөнхий гүйцэтгэгчийн амрах байрыг тениэр, зөвхөн Баянхөндий хээрийн ангийн гэрүүдийг нүүрсэн галлагаатай зуухаар халаадаг. Нүүрсийг Баянтээгийн нүүрсний уурхайгаас авсан, 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 6.1 тн нүүрс хэрэглэсэн.

## **БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

### **2.1. Физик газарзүй**

Физик газарзүйн мужлалын хувьд Монгол Алтайн их мужид, газарзүйн хэлбэр гадаргуугийн хэв шинжээр уулс хоорондын хөндийн хэв шинжид багтаан үздэг. Газрын гадаргын хувьд 1850-2010 м өргөгдсөн мөлгөрдүү оройтой намхан толгодтой, эдгээр нь өөр хоорондоо 25-40 метрийн өргөн хуурай сайраар тусгаарлагдсан, элэгдэл хуримтлалын рельеф зонхилно (Ш.Цэгмид 1967 он). Ашиглалтын талбай нь Эдрэнгийн нурууны зүүн төгсгөлд оршино.

### **2.2. Уур амьсгал**

Ашиглалтын талбайн нутаг дэвсгэр нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай. Агаарын урсгал үүсэхэд уул зүйн нөхцөл болон орон нутгийн бичил салхи нөлөөлж, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар, зундаа халуун дулаан, өвөлдөө хахир хүйтэн нөхцөлтэй бичил бүс нутгийг бүрдүүлдэг. Өвлийн улиралд цас бага ордог бөгөөд агаар нь хуурайвтар, чийг багатай, харин хавар салхи шуурга ихтэй, зарим үед 40 м/сек-ээс их хурдтайгаар шуурдаг. Үнэмлэхүй бага температур нь  $-37.4^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй их температур нь  $44.9^{\circ}\text{C}$  хүрдэг бөгөөд үнэмлэхүй их, бага температурын агууриг нь ( $82.3^{\circ}\text{C}$ ) эрс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь  $0.7^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 01 дүгээр сарын дундаж температур  $-15.5^{\circ}\text{C}$  байхад хамгийн дулаан буюу 07 дугаар сарын дундаж температур  $16.8^{\circ}\text{C}$  байдаг.

### **2.3. Гадаргын ус**

Ашиглалтын талбайн нутаг дэвсгэр нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай. Агаарын урсгал үүсэхэд уул зүйн нөхцөл болон орон нутгийн бичил салхи нөлөөлж, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар, зундаа халуун дулаан, өвөлдөө хахир хүйтэн нөхцөлтэй бичил бүс нутгийг бүрдүүлдэг. Өвлийн улиралд цас бага ордог бөгөөд агаар нь хуурайвтар, чийг багатай, харин хавар салхи шуурга ихтэй, зарим үед 40 м/сек-ээс их хурдтайгаар шуурдаг. Үнэмлэхүй бага температур нь  $-37.4^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй их температур нь  $44.9^{\circ}\text{C}$  хүрдэг бөгөөд үнэмлэхүй их, бага температурын агууриг нь ( $82.3^{\circ}\text{C}$ ) эрс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь  $0.7^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 01 дүгээр сарын дундаж температур  $-15.5^{\circ}\text{C}$  байхад хамгийн дулаан буюу 07 дугаар сарын дундаж температур  $16.8^{\circ}\text{C}$  байдаг.

### **2.4. Газрын доорх ус**

Баянхөндийн талбай нь гидрогеологийн дүүрэгчлэлээр улирлын хомс тэжээлтэй Монголын Өмнөдговийн хэсгийн дэд мужид багтана. Харин төслийн ойр орчмын дэвсгэр талбай нь Монгол орны гидрогеологийн мужлалаар (Н.Жадамбаа ба болон бусад, УБ 1988) хувирмал, терриген, вулканоген чулуулгаас бүрдсэн антиклиналь атираажилтай гидрогеологийн массивт хамаарна. Төслийн үйл ажиллагаа эрчимжиж эхэлсэн 2023 оны II улирлаас эхлэн улирал бүр үйлдвэрлэлийн зориулалтаар ус авч байгаа худгуудын усанд тогтмол шинжилгээ хийлгэж байна.

Усны чанарын 2019, 2022 - 2024 онуудын шинжилгээний үр дүнгээр Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд кальци, хлор, сульфат, ерөнхий хатуулаг, стронци, Хүрэнцав, Өргөө, Босго, Майхан хүрэнгийн хойд худгуудад магни, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Хүрэнцав, Майхан хүрэнгийн хойд, Босго худгуудын усанд никель, Майхан хүрэнгийн хойд худгийн усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгуудын усанд төмрийн агууламж тус тус Ундны усны стандарт (MNS 0900:2018)-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан байна.

Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд хлор, сульфат, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Гүн заг, Майхан хүрэн урд, хойд худгуудын усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгийн усанд төмөр гэсэн элементүүд тус тус Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 6148:2010) стандартаас тус тус давсан үзүүлэлттэй байна.

## 2.5. Хөрсөн бүрхэвч

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбай орчмын бүс нутагт цөлийн бор саарал хөрс зонхилон тархсан. Төслийн талбай орчимд тархсан бор саарал хөрс нь элсэнцэр, хэврэг бүтэцтэй, үржил шим багатай, эмзэг хөрс тархсан.

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайд ил уурхай, гадаад овоолгууд, баяжуулах үйлдвэр, уурхайн үйлчилгээ, хангамжийн барилга байгууламжуудыг 117.44 га талбайд байгуулахаар төлөвлөсөн. Барилга байгууламжуудыг барихаас өмнө хөндөгдөх талбайн өнгөн хөрсийг хуулж шимт хөрс хадгалах талбайд байршуулна. Нийт хөндөгдөх талбайгаас 0.8 тн ялмагийн агууламжтай 320.4 мян.м<sup>3</sup> шимт хөрс хуулагдана. Шимт хөрсний овоолгын үржил шимийг тогтвортой байлгах зорилгоор орой болон хажууг ургамжлуулна. Энэхүү шимт хөрсийг уурхайн ашиглалтын хугацаанд болон хаалтын үе шатанд эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд ашиглахаар төлөвлөсөн.

## 2.6. Ургамалан нөмрөг

Баянхөндий ордын байрлаж буй бүс нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Алтайн өвөр говийн цөлийн тойрог, цөлийн хээрийн бүсэд хамаарагддаг. Ургамалжилтын хувьд сийрэг, чулуут цөлийн хэвшинжид хамаарна. Энэ тойргийг ургамлын зүйлийн бүрдлийн хувьд их ядмаг боловч Алашаа говиос арай илүү гэж үздэг. Тус ордын талбайд гүйцэтгэсэн 3 удаагийн хээрийн судалгаагаар 57 зүйл ургамал тэмдэглэгдсэн бөгөөд ургамлын зүйлийн бүрдэлд сөөг, сөөгөнцөр (бүйлс, зээргэнэ, хармаг, хотир, бударгана, ортууз гэх мэт) зонхилсон. Мөн 2 зүйлийн мод (сухай, заг), 1 зүйлийн хагас шимэгч (Цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо) болон олон наст өвслөг ургамлууд ургадаг. Үүнээс гадна тухайн жилийн хур тундасны хэмжээнээс хамааран ургадаг эсвэл өнждөг нэг наст ургамлууд тохиолдоно.

Тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн байгаль орчны судалгаануудаар 57 зүйл ургамлаас нэн ховор 3 зүйл (Регелийн будраа, Толбот бэрээмэг, Потанины Хотир), ховор 2



зүйл (Монгол бүйлс, Өргөст ортууз) бүртгэгдсэн. Харин цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо Майхан хүрэнгийн худаас Цэнхэр Номин орох зам дагуу загийн ёроолоор шимэгчлэн ургадаг.

## **2.7. Амьтны аймаг**

Баянхөндий төслийн талбай нь бүхэлдээ ГИДЦГ-ын А хэсгийн Орчны бүсэд хамаарагдах тул нэн ховор, ховор зэрлэг амьтад, шувуудын байршил нутагтай давхцахаас гадна 10-20 км-ийн ойр байрладаг. Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд хөхтөн амьтдаас хар сүүлт, махчдаас чоно, үнэг шавж идэштнээс зараа, мэрэгчдээс алаг даага, шар чичүүл, бор шигшүүхэй жигүүртнээс цэгцгий, сар, хэрээ, хулан жороо, тас, цөлийн чогиго мөлхөгчдөөс хонин ба нохой гүрвэл, сум могой тархсан.

## **2.8. Нийгэм - Эдийн засаг**

Төслийн талбай нь манай орны дэд бүтэц сул хөгжсөн бүс нутагт байрлана. Хүн амын суурьшил маш багатай. Гол төлөв Халх ястан амьдардаг бөгөөд сумын хүн амын 90 орчим хувь нь мал аж ахуй эрхэлдэг. Хөндий талбай нь Шинэжинст, Баян-Өндөр сумдаас 130 орчим км зайтай оршино. Хамгийн ойр орших Шинэжинст сум нь талбайгаас 85 км-г байдаг бөгөөд энэ сум нь 2015 онд төвийн нэгдсэн цахилгаан сүлжээнд холбогдсон. Хүн эмнэлэг, холбооны салбартай, 9 жилийн дунд сургууль, ШТС-тай. Тээврийн үндсэн төрөл нь автомашин бөгөөд харилцдаг бүх газруудтайгаа шороон замаар холбогдоно.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 тусгай зөвшөөрөлтэй Хөндий талбайн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн барилгын үе шатны үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн хураангуйг доорх хүснэгтэд тоймлон үзүүлэв.

#### Хүснэгт 5. Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

| Сөрөг нөлөөлөл   | Нөлөөллийн эх үүсвэр                    |  |  |                                      |  |
|--|---|--|--|--------------------------------------|--|
|  | Барилгажилтын үе шат                    |  |  |                                      |  |
|  | Барилга байгууламж талбайн хөрс хуулалт | Зам ашиглалт/Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн | Барилгын материал тээвэрлэх, хадгалах, ашиглах | Барилга байгууламж, түр суурин барих | Хог хаягдал цуглуулах, устгах талбай байгуулах |
| <b>Газрын гадарга, хэвлий</b>  |   |  |  |                                      |  |
| <b>Гол сөрөг нөлөөлөл</b>  |   |  |  |                                      |  |
| Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 117.44 га газрын гадарга эвдрэлд орж, гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх, байгалийн үзэмжийг доройтуулах  | Т                                       | Т  | Т  | Т                                    | У  |
| <b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>  |   |  |  |                                      |  |
| Уурхайн ажилчдын хотхоноос гарсан хог хаягдал, уурхайн бусад барилга байгууламжуудын хатуу хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээр тухайн орчны газрын гадаргыг бохирдуулах                                  |   |  |  |                                      | У  |
| <b>Уур амьсгал</b>   |   |  |  |                                      |  |
| <b>Гол сөрөг нөлөөлөл</b>  |   |  |  |                                      |  |
| Энэ төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс жилд хамгийн ихдээ 61,599 тн нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг дээр дурдсан хэмжээгээр нэмэгдүүлнэ. |   | Д  |  |                                      |  |
| <b>Агаарын чанар</b>   |   |  |  |                                      |  |
| <b>Гол сөрөг нөлөөлөл</b>  |   |  |  |                                      |  |
| 108.83 га эвдэгдсэн талбайгаас цагт 39.24 кг тоос дэгдэн агаарын чанарт нөлөөлнө. Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.  |   | Б  |  |                                      |  |
| Тээврийн хэрэгслүүд болон дизель цахилгаан генераторуудаас жилд 61599 тн нүүрстөрөгчийн хий ялгарна.   |   | Б  |  |                                      |  |
| <b>Гадаргын ус</b>   |   |  |  |                                      |  |

|   |   |   |   |   |   |
|---|---|---|---|---|---|
| <b>Гол сөрөг нөлөөлөл</b>   |   |   |   |   |   |
| Ил уурхай, хүдрийн овоолго, авто зам байгуулснаар Хүрэн цавын сайрын голдирол өөрчлөгдөх  |   |   |   | Б |   |
| Шимт хөрсний овоолго, авто зам, автомашины зогсоол, ШТС, дулаан хангамжийн байгууламж, хаягдлын нэгдсэн байгууламж, хаягдлын талбайг байгуулснаар сайрын голдирол өөрчлөгдөх  |   |   |   | Б |   |
| <b>Газрын доорх ус</b>  |   |   |   |   |   |
| <b>Гол сөрөг нөлөөлөл</b>   |   |   |   |   |   |
| Газрын доорх усны тэжээмжийн талбай багасах   |   |   |   | Б |   |
| <b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>   |   |   |   |   |   |
| Химийн бодисоор бохирдсон ус асгарч алдагдаж болзошгүй;   |   |   | б |   |   |
| ШТМ асгаралт бий болж болзошгүй.  |   | б |   |   |   |
| <b>Хөрсөн бүрхэвч</b>   |   |   |   |   |   |
| <b>Гол сөрөг нөлөөлөл</b>   |   |   |   |   |   |
| Ил уурхайг ашиглах, барилга байгууламжуудыг барих явцад хөндөгдөх 117.44 га талбайгаас 0.8 тн ялзмагийн нөөц бүхий 320.4 мян.м3 шимт хөрс хуулагдана.   | У |   |   | Д |   |
| <b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>   |   |   |   |   |   |
| ШТМ алдагдсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох  |   | Д |   |   |   |
| Ашиглалт дууссан аккумуляторын шингэн, баяжуулах үйлдвэрт ашиглаж буй химийн бодис гоожиж, асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.   |   |   |   |   | Б |
| <b>Ургамлан нөмрөг</b>  |   |   |   |   |   |
| <b>Гол сөрөг нөлөөлөл</b>   |   |   |   |   |   |
| Барилгажилтын үе шатанд уурхайн овоолго, зам бусад дэд бүтцийн барилга байгууламжийг байгуулах 39.26 га талбайгаас 4 хэвшинжийн ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдана   | б | б | б | б |   |
| <b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>   |   |   |   |   |   |
| Барилгажилтын үеийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, газар хөндөх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурч, ургамлан нөмрөг доройтох                             | б | б | б | б |   |
| Ашиглалтын үед ил уурхай, хөрсний овоолгуудаас салхиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилтын улмаас ургамлан нөмрөгийн фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурснаар, ургамлын биомасс багасах |   |   |   |   | У |
| <b>Амьтны аймаг</b>   |   |   |   |   |   |
| <b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>   |   |   |   |   |   |
| Барилгын газар шорооны ажлын үед шувуудын үүр устгах, тэр дундаа Жороо тоодог ( <i>Chlamydotis undulata</i> ), Хулан жороо ( <i>Podoses hendersoni</i> )  | б | б | б | б |   |
| Барилгын ажилтнууд хууль бус ан хийх  |   | б | б | б |   |
| Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас зэрлэг амьтад тэр дундаа нүүдлийн том туруутан амьтад (хар сүүлт зээр) дайжсанаар амьдрах орчноо шууд бусаар алдах  |   | б | б | б |   |
| <b>Тусгай хамгаалалттай газар нутаг</b>   |   |   |   |   |   |

|  |  |   |  |  |  |
|--|--|---|--|--|--|
| <b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>  |  |   |  |  |  |
| Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тэсэлгээ хийх зэргээс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар Говийн их ДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд тархан амьдрах амьтад үргэж дайжих  |  | б |  |  |  |
| <b>Дуу шуугиан, доргион чичиргээ</b>   |  |   |  |  |  |
| <b>Гол сөрөг нөлөөлөл</b>  |  |   |  |  |  |
| Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс дуу шуугиан үүсэж, уурхайн 359 ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.  |  | б |  |  |  |
| <b>Нийгэм эдийн засаг</b>  |  |   |  |  |  |
| <b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>  |  |   |  |  |  |
| Баянхөндийн алтны үндсэн ордын ашиглах бүх үе шатанд барилгын материал, хүнс, хүн тээвэрлэх маршрутаар тээврийн хэрэгслүүд зорчих явцад үүссэн тоосжилт, дуу шуугианаас ойролцоо нутаглаж буй малчдад тавгүй байдал үүсэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй. |  | т |  |  |  |

## БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

### 4.1. Зорилго, зорилт

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2021 онд “Эко трейд” ХХК-ний боловсруулсан “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг, амлалтаас гадна Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

### 4.2. Баримтлах зарчим

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, БОАЖЯ-ны тусгай дансанд төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Эрдэнэ Монгол” ХХК байгаль хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

### 4.3. Хамрах хүрээ

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 дугаартай “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбайд 2024 онд дараах барилгуудыг барьж, 49,566м<sup>2</sup> талбайн ил уурхайгаас 710,673 тн буюу 268,178 м<sup>3</sup> хөрс хуулж, 10,000 тн хүдэр олборлож, 34,863 м<sup>2</sup> талбайд 348,632 м<sup>3</sup> эзэлхүүнтэй хөрсний овоолго, 41,549 м<sup>3</sup> шимт хөрсний овоолго үүсгэх ба геологи, хайгуулын ажил үргэлжлэн 20,000 т.м өрөмдлөг, 4,000 м суваг нэвтрэлтийн ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн. Гэхдээ эдийн засаг, хил гаалийн хүндрэл, бэрхшээл болон бусад урьдчилан таамаглах боломжгүй асуудлууд төслийн үйл ажиллагаанд нөлөөлсөн тул 2024 онд төлөвлөсөн уул, барилга, хайгуулын ажлуудын гүйцэтгэлийн хуваарьт өөрчлөлт орсон.

### Хүснэгт 6. Барилгын ажлын гүйцэтгэл

| Д/д                              | Барилга байгууламж              | Хүчин чадал | Талбайн хэмжээ /м <sup>2</sup> / | Эзэлхүүн /м <sup>3</sup> / | Барьж эхэлсэн огноо | Барьж дуусах огноо | Гүйцэтгэл |
|----------------------------------|---------------------------------|-------------|----------------------------------|----------------------------|---------------------|--------------------|-----------|
| <b>1. Түр барилга байгууламж</b> |                                 |             |                                  |                            |                     |                    |           |
| 1.1                              | Ерөнхий гүйцэтгэгчийн түр оффис | 55 хүн      | 480                              | 1,216                      | 2023.09.04          | 2023.12.13         | 100%      |

|                                      |  |   |       |         |            |            |        |
|--------------------------------------|--|---|-------|---------|------------|------------|--------|
| 1.2                                  | Захиалагчийн түр оффис                       | 30 хүн  | 250   | 985     | 2023.09.05 | 2023.11.10 | 100%   |
| 1.3                                  | Ажилчдын модуль кемп                         | 160 хүн   | 1,500 | 4,350   | 2023.07.06 | 2023.12.03 | 100%   |
| 1.4                                  | Гэр кемп                                     | 30 гэр  | -     | -       | 2023.07.06 | 2023.07.13 | 100%   |
| 1.5                                  | Барилгын талбайн ариун цэврийн байгууламж    | 5 суултуур<br>4 угаалтуур<br>7 хөтөвч                     | 24.7  | 68.1    | 2023.08.06 | 2023.08.09 | 100%   |
| 1.6                                  | Гэр кемпийн түр ариун цэврийн байгууламж     | 5 суултуур<br>7 угаалтуур<br>8 хөтөвч                     | 24.7  | 68.1    | 2023.07.21 | 2023.09.04 | 100%   |
| 1.7                                  | Ангаран агуулах                              | 1200 м <sup>3</sup>                                       | 310   | 1,210   | 2023.07.14 | 2023.11.27 | 100%   |
| 1.8                                  | Контейнер агуулах                            | 40 тн   | 30    | 72      | 2023.07.08 | 2023.07.21 | 100%   |
| 1.9                                  | Ажилчдын хоолны ангар                        | 150 хүн   | 407   | 1,400   | 2023.07.06 | 2023.10.12 | 100%   |
| 1.10                                 | Бэлдэц болон будгийн төв                     | 1300 м <sup>3</sup>                                       | 466   | 1,306   | 2023.08.08 | 2023.12.06 | 100%   |
| 1.11                                 | Түр дэд бүтэц                                | 80м шугам<br>2х30 тн танк<br>2200 м кабель                | -     | -       | 2023.07.06 | 2023.11.19 | 100%   |
| <b>2. Уурхайн барилга байгууламж</b> |  |   |       |         |            |            |        |
| 2.1                                  | Боловсруулах үйлдвэр                         | 650,000 тн/жил  | 8,694 | 159,652 | 2023.07.10 | 2025.02.16 | 57.04% |
| 2.2                                  | Баяжуулах үйлдвэрийн оффис                   | 29 хүн  | 184   | 1,025   | 2024.08.24 | 2024.12.04 | 20.95% |
| 2.3                                  | Уурхайн захиргааны барилга                   | 70 хүн  | 1,080 | 3,564   | 2023.09.07 | -          | 43.56% |
| 2.4                                  | Цианидын агуулах                             | 550 тн, 13 төрөл  | 276   | 1,008   | 2024.04.28 | -          | 29.23% |
|                                      | Хүчлийн агуулах                              |   | 80    | 288     | 2024.05.13 | -          |        |
|                                      | Хуурай бодисын агуулах "А"                   |   | 345   | 1,270   | 2024.05.20 | -          |        |
|                                      | Хуурай бодисын агуулах "Б"                   |   | 143   | 328     | 2024.05.20 | -          |        |
|                                      | Аюултай хог хаягдал түр хадгалах хэсэг       |   | 31    | 83      | 2024.05.27 | -          |        |
|                                      | Эмнэлэгийн тусламжийн барилга                |   | 50    | 150     | 2024.05.27 | -          |        |
| 2.5                                  | Агуулах                                      | 3400 м <sup>3</sup>                                       | 621   | 3,859   | 2024.03.13 | -          | 66.12% |
| 2.6                                  | Хүнд, хөнгөн машин механизмын засварын газар | 2 хүнд машин механизм,<br>1 тээврийн хэрэгсэл зэрэг засах | 2,516 | 27,215  | 2024.04.02 | 2024.12.26 | 22.70% |
| 2.7                                  | Халаалтын зуухны барилга                     | 2.8 мВт,<br>1.4 мВ  | 851   | 4,680   | 2024.03.22 | -          | 41.50% |
| 2.8                                  | Уурхайн шалган нэвтрүүлэх байр - 2           | 8 хүн   | 118   | 489     | 2024.05.02 | -          | 25.78% |

|      |   |                                    |        |       |            |            |        |
|------|---|------------------------------------|--------|-------|------------|------------|--------|
| 2.9  | Уурхайн шалган нэвтрүүлэх байр - 1                                      | 6 хүн                              | 76     | 161   | 2024.09.01 | 2024.12.01 | 1.98%  |
| 2.10 | Лабораторын барилга   | 135 дээж/өдөр                      | 450    | 1,816 | 2023.09.19 | -          | 44.89% |
| 2.11 | Усан хангамжийн систем  | 7820м шугам                        | -      | -     | 2024.08.15 | -          | 13.72% |
|      | Гүний худгийн барилга   | 4 ш                                | 13.8   | 69    | 2024.09.10 | -          | -      |
|      | 500м3 хос усан сан  | 1000 м3                            | 2x500  | 1,000 | 2024.08.28 | -          | -      |
|      | 50м3 хос усан сан   | 50 м3                              | 24     | 98    | 2024.09.10 | -          | -      |
|      | 50м3 ил усан сан  | 50 м3                              | 40     | 56    | 2024.09.04 | -          | -      |
| 2.12 | Гадна дулаан хангамж  | 2375 м шугам                       | -      | -     | 2024.05.06 | 2024.10.16 | 93.28% |
| 2.13 | Урвуу осмосын төхөөрөмжөөс хаягдал ус зайлуулах шугам                   | 900 м шугам                        | -      | -     | 2024.10.01 | 2024.11.28 | 0.00%  |
| 2.14 | Хаягдлын нэгдсэн сангийн ус цуглуулах сангаас Үйлдвэррүү ус шахах шугам | 900 м шугам                        | -      | -     | 2024.10.01 | 2024.11.28 | 0.00%  |
| 2.15 | Ахуйн хэрэглээний халуун, хүйтэн ус                                     | 3520 м шугам                       | -      | -     | 2024.05.06 | 2024.10.16 | 93.28% |
| 2.16 | Гадна галын ус хангамж  | 945 м шугам                        | -      | -     | 2024.05.06 | 2024.10.16 | 93.28% |
| 2.17 | Гадна бохир усны шугам  | 900 м шугам                        | -      | -     | 2024.05.22 | 2024.10.13 | 84.83% |
| 2.18 | Уурхайн ахуйн ус Цэвэрлэх байгууламж                                    | 40 м <sup>3</sup> /хоног           | 66     | 462   | 2024.03.25 | -          | 45.80% |
|      | Цэвэрлэх байгууламж-Техникийн байр                                      |                                    | 16     | 48    | 2024.03.25 | -          |        |
| 2.19 | Цахилгааны дэд өртөө  | 4x2500 kVA                         | 218    | 874   | 2024.05.15 | -          | 33.60% |
| 2.20 | Давтамж хувиргуурын байгууламж  | 2.25 MVA, 2.8 MVA                  | 75     | 234   | 2024.06.24 | -          | 22.97% |
| 2.21 | Гадна холбооны шугам сүлжээ   | 9340 м кабель                      | -      | -     | 2024.08.20 | -          | 1.17%  |
| 2.22 | Уурхайн өндөр хүчдэлийн шугам   | 11 kV, 4x800 м, 240мм <sup>2</sup> | -      | -     | 2024.08.20 | -          | 1.17%  |
| 2.23 | Уурхайн гэрэлтүүлэг   | 43x150W                            | -      | -     | 2024.08.20 | -          | 1.17%  |
| 2.24 | Уурхайн газардуулгын систем   | -                                  | -      | -     | 2024.08.20 | -          | 1.17%  |
| 2.25 | Уурхайн гадна камерын систем  | ш камер                            | -      | -     | 2024.08.20 | -          | 1.17%  |
| 2.26 | Ил уурхай /хаягдлын нэгдсэн сан/  | -                                  | 49,566 | -     | -          | -          | -      |
| 2.27 | Шатахуун түгээх байгууламж  | -                                  | -      | -     | -          | -          | -      |

| 3. Уурхайн кемпийн барилга байгууламж |   |                          |      |       |            |            |        |
|---------------------------------------|---|--------------------------|------|-------|------------|------------|--------|
| 3.1                                   | Уурхайн ажилчдын кемп А- Block                | 370 хүн                  | 522  | 1,598 | 2024.06.06 | 2024.11.09 | 16.53% |
|                                       | Уурхайн ажилчдын кемп В- Block                |                          | 679  | 7,634 | 2024.06.06 | 2024.12.03 | 32.16% |
|                                       | Уурхайн ажилчдын кемп С- Block                |                          | 679  | 7,554 | 2024.06.24 | 2024.12.25 | 22.99% |
|                                       | Уурхайн ажилчдын кемп D- Block                |                          | 713  | 5,338 | 2024.06.25 | 2024.12.05 | 8.24%  |
|                                       | Уурхайн ажилчдын кемп E- Block                |                          | 773  | 5,244 | 2024.06.25 | 2024.12.05 | 8.54%  |
|                                       | Уурхайн ажилчдын кемп F- Block                |                          | 727  | 3,179 | 2024.06.06 | 2024.12.09 | 17.57% |
| 3.2                                   | Кемп - Халаалтын зуухны барилга               | 0.7 мВт х 3 = 2.1 мВт    | 648  | 3,960 | 2024.06.06 | 2024.12.17 | 10.19% |
| 3.3                                   | Кемп - Хувцас угаалга, авто зогсоолын барилга | 8 машин                  | 546  | 2,868 | 2024.08.27 | 2024.11.10 | 13.43% |
| 3.4                                   | Кемп - Шалган нэвтрүүлэх байр                 | 8 хүн                    | 75.8 | 160.5 | 2024.08.27 |            | 35.48% |
| 3.5                                   | Кемп - Харуулын байр                          | 1-2 хүн                  | 15.2 | 34.9  | 2024.08.27 |            | 0.00%  |
| 3.6                                   | Кемп - Гадна дулаан                           | 372 м шугам              | -    | -     | 2024.08.12 | 2024.10.15 | 65.00% |
| 3.7                                   | Кемп - Гадна цэвэр ус                         | 757 м шугам              | -    | -     | 2024.08.12 | 2024.10.15 | 0.00%  |
| 3.8                                   | Кемп - Гадна бохир ус                         | 503 м шугам              | -    | -     | 2024.08.12 | 2024.10.15 | 60.00% |
| 3.9                                   | Кемп - Бохир ус цэвэрлэх байгууламж           | 80 м <sup>3</sup> /хоног | 95   | 665   | 2024.07.11 | 2024.12.13 | 11.90% |
|                                       | Цэвэрлэх байгууламж-Техникийн байр            |                          | 16   | 48    | 2024.10.07 | 2024.11.27 |        |
| 3.10                                  | Кемп - Гадна цахилгаан                        | 1000 kVA КТРН            | -    | -     | 2024.09.13 | 2024.12.13 | 0.00%  |
| 3.11                                  | Кемп - Гадна гэрэлтүүлэг                      | 34x150 W                 | -    | -     | 2024.09.13 | 2024.12.13 | 0.00%  |
| 3.12                                  | Кемп - Гадна холбоо дохиолол                  | 1125 м кабель            | -    | -     | 2024.09.13 | 2024.12.13 | 0.00%  |
| 3.13                                  | Кемп - Гадна камерын систем                   | ш камер                  | -    | -     | 2024.09.13 | 2024.12.13 | 0.00%  |

Баянхөндий төслийн талбайд 2023 онд эхэлсэн барилга угсралтын үе шат үргэлжлэн явагдаж байгаагийн зэрэгцээ хайгуулын өрөмдлөгийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж 10 дугаар сарын 16-ны байдлаар 2453.9 т.м өрөмдлөг, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажлын хүрээнд 120 т.м өрөмдлөг, 32 м<sup>3</sup> уулын малталтын ажлыг гүйцэтгэсэн.

#### 4.4.Холбогдох зөвшөөрлүүд:

##### Хүснэгт 7. Ус ашиглах зөвшөөрөл

| Д/д | Зөвшөөрөл                        | Огноо, дугаар              | Хүчинтэй хугацаа |
|-----|----------------------------------|----------------------------|------------------|
| 1   | Ашиглах боломжит нөөцийн дүгнэлт | Усны газар 2020.09.23 №158 | -                |



|   |                         |   |            |
|---|-------------------------|---|------------|
| 2 | Ус ашиглуулах дүгнэлт   | Усны газар 2024.03.19 №31                         | 2024.12.31 |
| 3 | Ус ашиглуулах зөвшөөрөл | АӨГСГ-ын Захиргааны даргын тушаал 2024.04.30 А/07 | 2029.04.30 |
| 4 | Ус ашиглах гэрээ        | АӨГСГ-ын Захиргаа 2024.04.23 №24/03               | 2025.04.23 |

#### 4.5. Байгаль орчны үнэлгээ

##### Хүснэгт 8. Байгаль орчны үнэлгээ

| №  | Үнэлгээний нэр   | Батлагдсан он |
|----|--|---------------|
| 1. | Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ – Эко трейд ХХК                        | 2017          |
| 2. | Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ – Састэйнабилити Ийст Эйжия ХХК | 2020          |
| 3. | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ - “Эко трейд” ХХК     | 2021          |

Бид хайгуулын үе шатнаас эхлэн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн холбогдох дүрэм, журмуудыг баримтлан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилгоо биелүүлж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн орон нутгийн хамтын ажиллагааг хангаж ажилласаар ирсэн.

#### 4.6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон тусгасан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 147.97 сая төгрөг төлөвлөж 506.3 сая төгрөг, “Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн”-д 65 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 156.62 сая төгрөгийг зарцуулсан. Төслийн БОМТ-г хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлуудын хураангуйг доор харуулав.

##### Хүснэгт 9. БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2024 он

| №  | Хэрэгжүүлсэн арга хэмжээ   | Зардал, төг.           |
|----|--|------------------------|
| 1. | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө                | 214,95 сая             |
| 2. | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө                                     | 62,09 сая              |
| 3. | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө        | 79,70 сая              |
| 4. | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | Үйл ажиллагааны зардал |

|   |   |                        |
|---|---|------------------------|
| 5.                                      | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө                            | 1,80                   |
| 6.                                      | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө   | Үйл ажиллагааны зардал |
| 7.                                      | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө  | 91,75 сая              |
| 8.                                      | Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр  | 4,74 сая               |
| 9.                                      | Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө   | 40,99 сая              |
| 10.                                     | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах | 10,25                  |
| <b>Нийт</b>                             |   | <b>506,3 сая</b>       |
| <b>Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт</b> |   | <b>156,62 сая</b>      |

#### 4.7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрс, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтан, ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах, арилгах зэрэг чиглэлүүдээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд  | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ   | Баримтласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага  | Хэрэгжүүлсэн арга хэмжээ  | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|---|--|---|---|---------------------------------|
| <b>НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>   |  |   |   |                                 |
| Барилга байгууламжууд барих хөрс хуулалт хийх, уурхайн доторх зам ба талбайд газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх | Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх | MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, “Эрдэнэ”-ийн бодлого журмын гарын авлага  | Төслийн үйл ажиллагааны үндсэн болон туслах барилга байгууламжуудыг барих, зам гаргах, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох зэрэг газар шорооны ажил эхлүүлэх бүрт “Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл”-ийг олгодог. Газар шорооны ажил эхлүүлэх бүрт шимт хөрсийг 30см зузаантай хуулан авч шимт хөрсний овоолгын талбайд байршуулдаг. Шимт хөрсийг хуулсны дараа “Шимт хөрс хуулах үзлэгийн хуудас”-ны дагуу үзлэг хийж, хангалттай хуулсан тохиолдолд ажлыг үргэлжлүүлдэг. Тайлант онд 10 дугаар сарын 20-ны байдлаар 26 ш газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон. Газар шорооны ажлыг гүйцэтгэж дуусгасны дараа уг зөвшөөрлийг хааснаар ажил дууссан гэж үздэг. Олгогдсон 26 ш зөвшөөрлөөс 6 зөвшөөрөл хаагдаж, үлдсэн талбайд ажил үргэлжлэн явагдаж байна. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл тус бүрт тухайн ажлын талаарх мэдээлэл, байршлыг харуулсан .dwg болон ажил эхлэхээс өмнөх болон ажил гүйцэтгэсний дараах байдлыг харуулсан фото зургийг агуулсан хавтсыг үүсгэж Sharepoint-д байршуулдаг.<br><i>Хавсралт 6. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн жагсаалт – 2024он</i> | -                               |
|   | Үйл ажиллагааны багуудад газар шорооны ажил эхлэх зөвшөөрөл олгохтой холбоотой сургалт зохион байгуулах  | “Газар шорооны ажлын зөвшөөрөл олгох” журмын сургалтыг 2024 оны 1 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд ерөнхий гүйцэтгэгчид зохион байгуулж 91 ажилтан хамрагдсан, 9 дүгээр сарын 24-нд Гложекс консалтинг ХХК-ийн ажилтнуудад зохион байгуулж 25 ажилтан хамрагдсан.<br><i>Хавсралт 7. Сургалтад оролцогчдын бүртгэл</i><br><i>Хавсралт 8. Сургалтын материал</i> | -   |                                 |

|  |  |   |  |                        |
|--|--|---|--|------------------------|
|  | Барилга байгууламж барих үйл ажиллагааны үед олон салаа зам гаргахгүй, шаардлагатай тохиодолд дотоод замын маршрутыг шинэчлэн батлаж, мөрдүүлэх            | ТЭЗҮ-д тусгагдсан уурхайн замын төлөвлөлт, түүний ашиглалтын хугацаатай уялдуулан гүйцэтгэнэ.   | Барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой түр замуудыг гарган, өдөр бүр услан ашиглаж байна.<br><i>Хавсралт 9. Дотоод замын маршрут</i>   | -                      |
|  | Шаардлагатай цэгүүдэд замын тэмдэг байрлуулах  | Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйл, 17.3 дахь заалт, 23 дугаар зүйл 23.1 дэх заалт, MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм | “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартын дагуу Баянхөндий төслийн талбайн үндсэн болон туслах замуудын уулвар, эргэх тойруу, салах хэсгүүдэд заах, анхааруулах болон хориглох тэмдэгүүдийг байршуулахын зэрэгцээ орон нутгийн тээврийн зам дагуу тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан. Нийт 34 ширхэг тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан. | 17,505                 |
| Хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг стандартын дагуу зөв хадгалж, ашиглах  | Шимт болон шимэрхэг хөрсний үржил шим алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (5 метрээс өндөргүй овоолох) | MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт                                    | Шимт хөрсний овоолгыг “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008” стандартын дагуу 5 хүртэл метрийн өндөртэй үүсгэж байна. Төслийн хэмжээнд 2 талбайд шимт хөрсний овоолгыг үүсгэсэн, уурхайн бүсэд 19409.78 кв.м талбайд 40498.2 куб.м, ажилчдын кэмп орчимд 5412.21 кв.м талбайд 3557.29 куб.м шимт хөрсний овоолгыг үүсгээд байна.                              | Үйл ажиллагааны зардал |
| <b>ХОЁР. ХӨРСӨН БҮРХЭВЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>   |  |   |  |                        |
| Тээврийн хэрэгслүүдийн явах эд ангиуд гэмтэх, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ гоожиж, асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй. | Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтад авах арга хэмжээний дотоод журмыг хэрэгжүүлэх  | “Эрдэнэ”-ийн бодлого журмын гарын авлага. Сонгож авсан шингээгч материалгыг хэрэглэх зааварчилгаа   | “Асгаралтын хариу арга хэмжээний журам”-ыг 2013 оны 06 сарын 12-ны өдөр гүйцэтгэх захирлын EM2023/0002.01 тоот тушаалаар батлуулан, мөрдлөг болгон ажиллаж байна.<br><br><i>Хавсралт 10. Асгаралтын хариу арга хэмжээний журам</i>   | -                      |

|  |  |   |   |                               |
|--|--|---|---|-------------------------------|
| <p>Барилгын ажлын үед машин, механизмуудын засварын газраас гарсан ашигласан тос, тослох материалыг түр хадгалах саванд цуглуулах, түр хадгалах явцад дамжуулах шугам хоолойн гэмтэл, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдуулж болзошгүй</p> | <p>Авто машины засварын газраас гарах ашигласан тос, тосолгооны материалыг зориулалтын саванд хуульд заасан хугацаанд түр хадгалах</p> | <p>“Шатахуун түгээх станц, Галын аюулгүйн норм” /БНБД 21-07-14/</p>   | <p>Үйл ажиллагаанд хэрэглэж байгаа химийн бодис болон үүссэн аюултай хог хаягдлыг бүртгэн, түр хадгалах цэгт хуульд заасан хугацаанд хадгалж, “Элемент” ХХК-д 2 удаа нийлүүлэн, 1 удаа 720 кг аюултай хог хаягдлыг устгалд оруулсан.<br/><i>Хавсралт 11. Аюултай хог хаягдлыг устгасан акт</i></p>  | <p>Үйл ажиллагааны зардал</p> |
| <p>Ачаа тээврийн ажиллагаанаас олон салаа зам гарган хөрсний элэгдэл үүсгэж болзошгүй</p>  | <p>Шаардлагатай цэгүүдэд замыг сайжруулах ажлыг зохион байгуулах</p>   | <p>Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3);</p>   | <p>Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Замын чиглэл тогтоох тухай” А/396 дугаар захирамжаар батлагдсан чиглэлээр тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Батлагдсан маршрутын дагуу Шинэжинст сумаас төслийн талбай хоорондох замыг хэсэгчлэн сайжруулах ажлыг Өсөх Урам ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээний хүрээнд хийгдэх ажилд шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж, бэлтгэл ажлыг ханган, зам засварын ажлыг 10 дугаар сарын 22-оос эхлүүлсэн.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> |
| <p><b>ГУРАВ. УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b></p>  |  |   |   |                               |
| <p>Төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс нүүрхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлнэ.</p>  | <p>Түлшний хэрэглээ бүртгэх, ялгаруулж байгаа хүлэмжийн хийг тооцох</p>  | <p>*MNS ISO 14064-1 - 2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж)<br/>*Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06)</p> | <p>Төслийн талбайд 10 дугаар сарын 24-ний байдлаар нийт 21.5 тн шатахуун, 228.0 тн дизель түлш хэрэглэсэн. MNS ISO 14064-1-2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж) стандартыг худалдан авч, хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг урьдчилан тооцоход 650.3 тн CO<sub>2</sub> ялгаруулсан тооцоо гарсан.</p>  | <p>-</p>                      |

| <b>ДӨРӨВ. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>   |   |   |   |                        |
|--|---|---|---|------------------------|
| Эвдрэл, элэгдэлд өргсөн, хөрсөн бүрхэвч талхлагдсан хэсгүүдээс тоос шороо агаарт дэгдэх  | Замын усалгааг хуваарийн дагуу хийх   | Усны тухай хууль (2012) 32.8 дугаар зүйл                                      | Агаар дахь тоосонцрын хэмжээг стандартаас давуулахгүй байх зорилгоор зам, талбайн усалгааг өдөр бүр хийж байна.<br>Барилга угсралтын талбай доторх зам, талбайг ерөнхий гүйцэтгэгч, хаягдлын нэгдсэн сангийн талбайг гүйцэтгэгч Гложекс консалтинг ХХК, тусгай ллозөвшөөрлийн талбай доторх талбайн усалгааг Монруд ХХК гүйцэтгэдэг. Тээврийн замын дагуу Шинэжинст сумын төвөөс Цагаан хаалга хооронд Шинэжинст сумын иргэн Дашжамц, Цагаан хаалга Үзүүр худаг хооронд Өсөх Урам ХХК, Үзүүр худаг Онцонгийн шал хооронд Залаа таун ХХК, Онцонгийн шал Майхан хүрэн хооронд иргэн Ш.Дэлгэрбат, Майхан хүрэнгээс төслийн талбай, ургамал үржүүлгийн талбайн замыг Залаа таун ХХК усалж байна. Тусгай зөвшөөрлийн талбай доторх зам, талбайн усалгааг 20 тн хүртэлх багтаамжтай зориулалтын автомашинуудаар өдрийн цагаар хийж, хоногт дунджаар 77 км тээврийн зам, барилга баригдаж байгаа талбай болон түр замуудыг усалж, тайлант хугацаанд тээврийн замын усалгаа болон төслийн дотоод зам, талбайн усалгаанд 18566 м <sup>3</sup> усыг зарцуулсан. | 117,448                |
|  | Тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцох хурдны дээд хязгаарыг 40 км/цагаас хэтрүүлэхгүй байх |   | “ОНСЕ.ЕМ-101 Замын хөдөлгөөний журам”-д хурдны дээд хязгаарыг Майхан хүрэнгийн худгаас эхлэн 40 км/цаг, төслийн талбай дотор 20 км/цаг, төслийн талбайн суурин бүсийн орчимд 20 км/цаг, кемпийн хашаан дотор 5 км/цаг байхаар заасан.<br>Шинэ ажилтны сургалт болон төслийн талбайд жолоо барих эрх олгох сургалтаар хурдны дээд хязгаарын талаар нарийвчлан заадаг ба замын хурдны дээд хязгаарын 20 ш тэмдэгүүдийг байршуулсан.<br>Мөн хурд хэмжигчээр хуваарийн дагуу хэмжилт хийж, хурд хэтрүүлсэн ажилтнуудад зөрчлийн сануулах арга хэмжээ авах, сургалт сурталчилгаа хийх ажлыг тогтмол хийж хэвшсэн.  | Үйл ажиллагааны зардал |
| Барилгын ажлын үед машин техникийн яндан, дизель цахилгаан генераторуудаас бохирдуулагчид агаарт хаягдан агаарын чанарт нөлөөлөх | Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн улсын үзлэгт хамруулах                                      | Агаарын тухай хууль MNS 4585 :2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага | Ачаа ачиж болон хүн тээврийн зориулалтаар ирсэн, төслийн талбайгаас буцах тээврийн хэрэгслүүдэд бүрэн бүтэн байдлын үзлэг шалгалтыг тухайн ахуйн нэгжийн хариуцсан инженер техникийн ажилчид гүйцэтгэж төслийн талбайд нэвтрэх, талбайгаас гарах зөвшөөрлийг олгодог. Төслийн талбайд тогтмол ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүдэд ХАБ-ын хэсэг ажилтан холбогдох инженерүүдтэй хамтран тээврийн хэрэгслийн үзлэгийг гүйцэтгэж нэгдсэн бүртгэл оруулан, стикер дугаар олгодог. Төслийн талбайд 155 ш тээврийн хэрэгсэлд стикер дугаар буюу төслийн талбайд замын хөдөлгөөнд оролцох эрхийг олгосон.   | -                      |
| <b>ТАВ. ГАДАРГЫН УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>   |   |   |   |                        |

|   |   |   |  |                        |
|---|---|---|--|------------------------|
| Түр байгууламж, уурхайн доторх замыг сайрууд дээр байгуулснаар сайрын гольдрол өөрчлөгдөх | Хөв цөөрөм байгуулах боломжтой газрын судалгааг хийх  | Усны тухай хууль, 32.1 Хидро Инженеринг ХХК, Баянхөндий алтны уурхайн зам талбайн борооны ус шүүрүүлэх байгууламжийн зураг төсөл, 2020. Усны эрчим ХХК, Баянхөндий алтны уурхайн хаягдлын сангийн зураг төсөл, 2021 | Төслийн талбайн 50 км радиуст хөв байгуулах боломжтой газрын байршлын судалгааг өмнө хийгдсэн судалгаанууд болон сансрын зураг ашиглан хийхэд 13 байршилд ус хуримтлагдах боломжтой байсан. Ус хуримтлагдах боломжтой газруудаас хөв байгуулахад төслийн талбайтай хамгийн ойр байршилтай нь Босгын сайр байна.<br><i>Хавсралт 12. Хөв байгуулах боломжтой газрын байшлын зураг</i>                  | -                      |
| <b>ЗУРГАА. ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>           |   |   |  |                        |
| Газрын доорх усны нөөц багасгах   | Ус авах худаг нэмэгдсэн тохиолдолд тухайн ус хангамжийн эх үүсвэрийг тоолууржуулах  | Усны тухай хууль 30.1.4; Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны "Журам батлах тухай" 156 тоот тушаал  | Төслийн ахуйн хэрэглээний ус авч ашигладаг Уртын гол /BKW-21/ худагт 2023 оны 08 дугаар сарын 06-нд LGX 40мм голчтой, хүйтэн усны, үйлдвэрийн ус авдаг Уртын гол /BKW-30/ LGX 40мм голчтой, хүйтэн усны, Шинэ кэмгийн худагт 2023 оны 06 дугаар сарын 20-нд LGX 32 мм голчтой, хүйтэн усны баталгаат тоолуурыг суурилуулсан.   | -                      |
|   | Ус хангамжийн худгуудын тоолуурын заалтыг тогтмол бүртгэх, сумын байцаагч эсвэл байгаль хмагаалагчаар баталгаажуулах ажлыг зохион байгуулах | Усны тухай хууль  | Ус авсан тухай бүрт усны тоолуурын заалтыг бүртгэдэг. Усны тоолуурын заалтыг Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч төслийн талбайд ажиллах үедээ бүртгэлтэй тулгалт хийдэг. Усны тоолуурын заалтын 7 дугаар сарын 19-ийг дуустал бүртгэлд баталгаажуулалт хийгдсэн.<br><i>Хавсралт 13. Усны тоолуурын заалтын бүртгэл</i>  | -                      |
|   | Гидрогеологийн хайгуулын ажлын үр дүнг баталгаажуулах   | Усны тухай хууль  | Усны нөөцийн зөвлөлийн хурлаар 2024 оны 5 сард хэлэлцэгдэж нэмэлтээр гадаргын усны судалгааг хийж ирүүлэх даалгаврын дагуу судалгааг гүйцэтгэн боловсруулж Усны нөөцийн зөвлөлд 08 дугаар сард хүргүүлсэн ба одоогоор нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.  | -                      |
|   | Усыг хэмнэлттэй, зохистой ашиглах сургалт, мэдээллийг ажилтнуудад хийх  | Усны тухай хууль  | Байгаль орчны мэдлэг олгох сургалтын төлөвлөгөөний дагуу “Ус хэмнэх” сургалтыг 3 дугаар сарын 23-нд зохион байгуулж 125 ажилтан, 6 дугаар сарын 24-нд 23 ажилтан хамрагдсан.<br><i>Хавсралт 14. Сургалтад оролцогчдын бүртгэл</i>  | -                      |
| ШТМ, аюултай болон хортой бодис асгарч, хаягдсан тохиолдолд газрын доорх усыг бохирдуулах | Усны сан бүхий газрын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах   | Усны тухай хууль  | Усны тухай хуулийн дагуу газрын доорх усны ордын нөөц шинэчлэгдэн батлагдсны дараа ус хангамжийн худгуудад эрүүл ахуйн бүс тогтоолгох хүсэлтийг Алтайн өвөр говийн сав газрын захиргааны дүгнэлтийн хамт Шинэжинст сумын ИТХ-д дахин уламжлахаар төлөвлөсөн.<br>Шинэ кэмгийн худагт хамгаалалтын хашааг 50 м радиустай татсан ба усны сан бүхий газар хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий тэмдгийг | Үйл ажиллагааны зардал |



|  |  |  |  |   |
|--|--|--|--|---|
|  |  |  | байршуулсан. Үйлдвэрийн ус авдаг ВКW-30 худгаас 100 м зайд усны сан бүхий газар хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий тэмдгийг байршуулсан.  |   |
| <b>ДОЛОО. УРГАМАЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>                        |  |  |  |   |
| Уурхайн түр байгууламжууд, агуулах барих, зам засах үед ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдах | Уурхайн барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтаар үүссэн түр, зам талбайг хааж, байгалийн аясаар ургамал ургах нөхцлийг бүрдүүлэх                         | Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3);   | Тайлант онд барилга угсралтын ажил үргэлжлэн явагдаж аль болох өмнө үүссэн замуудыг ашигласан. Ачаа тээвэрт түвэгшил ихтэй зам байсан учраас хайгуулын шатнаас хэрэглэж байсан төслийн дотоод замыг 4 км газар хааж, 2018 оноос өмнө хэрэглэж байсан хуучин замыг эргүүлэн ашиглаж эхэлсэн.<br><i>Хавсралт 15. Төслийн дотоод замын маршрут – 2024он</i>   | - |
| Түр байгууламжууд, агуулах барих, зам засахад ховор ургамлууд нөлөөлөлд өртөх                        | Газар хөндөлтийн өмнө тухайн талбайд дахь нэн ховор, ховор ургамлыг бүртгэх  | Монголын ургамлын улаанданс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл, 2012, 2019   | Газар шорооны ажил эхлэхийн өмнө уг талбайд ховор болон нэн ургамал илэрсэн тохиолдолд шилжүүлэн суулгах зорилгоор үзлэг хийн ургамлыг бүртгэдэг. Зөвшөөрөл олгогдсон 36 талбайд ажил эхлэхийн өмнөх үзлэгээр нэн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй.<br><i>Хавсралт 6. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн жагсаалт – 2024он</i>   | - |
|  | Нөлөөлөлд өртөх ховор зүйлийн ургамлыг шилжүүлэн тарих   |  | Зөвшөөрөл олгогдсон 26 талбайд ажил эхлэхийн өмнөх үзлэгээр нэн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй учраас шилжүүлэн тариалалт хийгдээгүй.   | - |
| Хүн амын суурьшил нэмэгдсэнээр заг, бутлаг ургамлыг түүж болзошгүй                                   | Хууль бусаар ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглон, уурхайн шалган нэвтрүүлэх хэсэг, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийх | Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES); Ойн тухай хууль 29.1.11 | Тээврийн хэрэгсэл төслийн талбайд ирэх, явах тохиолдол бүрт, ажилд гарахын өмнө үзлэг шалгалтыг тогтмол хийж хэвшсэн. Ажилтнууд ээлжинд ирэх, буух бүрт цүнхний үзлэгийг хийдэг. 2024 онд 1071 ш тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийсэн. Заг бутлаг ургамал хадгалсан, тээвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй.<br><i>Хавсралт 16. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийсэн бүртгэл</i>                      | - |
| Байгаль орчны мэдлэг дутуугаас ургамал тасдаж болзошгүй  | Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Биологийн олон янз байдлын мэдлэг олгох” сургалтад хамруулах   | Уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны сургалт, зааварчилгаа, дотоод журам   | “Баянхөндий төсөл хүрээлэн буй орчин ургамал хамгаалал сургалт”-ыг 4 дүгээр сарын 13-нд захиалагч болон ерөнхий гүйцэтгэгчийн ажилтнуудад зохион байгуулж 207 ажилтан хамрагдсан ба 9 дүгээр сарын 24-нд Гложекс консалтинг ХХК-ийн ажилтнуудад зохион байгуулж 25 ажилтан хамрагдсан.<br><i>Хавсралт 17. Сургалтад хамрагдсан ажилтнуудын бүртгэл</i><br><i>Хавсралт 18. Сургалтын материал</i> | - |
| <b>НАЙМ. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>                             |  |  |  |   |



|   |   |   |  |          |
|---|---|---|--|----------|
| <p>Хүн амын суурьшил; тээврийн хэрэгслийн дуу чимээ, гэрэл зэргээс амьтад байршиж буй газар нугаасаа үргэж дайжихаас гадна, тээврийн хэрэгсэлд дайруулж болзошгүй</p> | <p>Зөвхөн батлагдсан замын сүлжээг ашиглах ба тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоож, мөрдүүлэх</p>   | <p>Уурхайн дотоод журам болон аюулгүй ажиллагаа, байгаль орчны зааварчилгаа</p>   | <p>Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд батлагдсан маршрутын дагуу зорчихыг, зэрлэг амьтныг үргээх, элдэж хөөхийг хориглох мэдээллийг Ерөнхий зааварчилгаа болон Биологийн төрөл зүйлийг хамгаалах сургалтын дагуу өгч ажилладаг.<br/>“OHSE.EM-101 Замын хөдөлгөөний журам”-д хурдны дээд хязгаарыг Майхан хүрэнгийн худагас эхлэн 40 км/цаг, төслийн талбай дотор 20 км/цаг, төслийн талбайн суурин бүсийн орчимд 20 км/цаг, кемпийн хашаан дотор 5 км/цаг байхаар заасан.<br/>Шинэ ажилтны сургалт болон төслийн талбайд жолоо барих эрх олгох сургалтаар хурдны дээд хязгаарын талаар нарийвчлан заадаг ба замын хурдны дээд хязгаарын 20 ш тэмдэгүүдийг байршуулсан.<br/>Мөн хурд хэмжигчээр хуваарийн дагуу хэмжилт хийж, хурд хэтрүүлсэн ажилтнуудад зөрчлийн сануулах арга хэмжээ авах, сургалт сурталчилгаа хийх ажлыг тогтмол хийж хэвшсэн.</p> | <p>-</p> |
|   | <p>ОХШХ-ийн дагуу амьтны хяналт мониторингийг хэрэгжүүлж, бүртгэл хөтлөх</p>  | <p>Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025</p>   | <p>Төслийн талбай дотор болон ойр орчимд амьтан тааралдах бүрт байгаль орчны хэсэгт мэдэгдэн, бүртгэдэг. Тайлант хугацаа буюу 10 дугаар сарын 20-ны байдлаар давхардсан тоогоор 4 зүйлийн хөхтөн 156 бодгаль, 3 зүйлийн мөлхөгч 3 бодгаль, 22 зүйлийн 1044 шувуу бүртгэгдсэн.<br/><i>Хавсралт 19. 2024 оны амьтны бүртгэл</i></p>  | <p>-</p> |
| <p>Байгаль орчны мэдлэг дутуугаас амьтныг үргээж, элдэж, алж болзошгүй</p>  | <p>Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Биологийн олон янз байдлын мэдлэг олгох” сургалтад хамруулах</p>   | <p>Уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны сургалт, зааварчилгаа, дотоод журам хамруулах</p>   | <p>“Биологийн олон янз байдлын мэдлэг олгох” сургалтыг 2 дугаар сарын 11-нд, “Говийн гайхамшигт-6” сургалтыг 2 дугаар сарын 21-нд захиалагч болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудад зохион байгуулж 245 ажилтан хамрагдсан.<br/><i>Хавсралт 20. Сургалтын тайлан</i></p>   | <p>-</p> |
| <p>Хүн амын суурьшил нэмэгдсэнээр хууль бус ан хийгдэж болзошгүй</p>  | <p>Хууль бусаар амьтан агнах, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох, уурхайн шалган нэвтрүүлэх хэсэг, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийх</p> | <p>Амьтны тухай хууль, 2012 6.1.7 үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх; Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)</p> | <p>Тээврийн хэрэгсэл төслийн талбайд ирэх, явах тохиолдол бүрт, ажилд гарахын өмнө үзлэг шалгалтыг тогтмол хийж хэвшсэн. Ажилтнууд ээлжинд ирэх, буух бүрт цүнхний үзлэгийг хийдэг. 2024 онд 1071 ш тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийсэн. Хууль бус ан хийсэн, амьтны гаралтай түүхий эд, хадгалсан, тээвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй.<br/><i>Хавсралт 16. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийсэн бүртгэл</i></p>   | <p>-</p> |

|   |        |   |  |  |        |
|---|--------|---|--|--|--------|
| Шувууд болзошгүй  | эрсдэж | Шувууд (элдэв идэшт) цуглах таатай орчин бүрдүүлэхээс зайлсхийж хоол хүнсний үлдэгдлийг ил задгай хаяхгүй бай, холбогдох хяналт тавих | Уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө                                 | Хог хаягдлын тухай хуулийн 15, 16 дугаар зүйл, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018.11.17-ны “Тавигдах ерөнхий шаардлага батлах тухай” А/443, 2018.11.19-ний “Аргачилсан заавар батлах тухай” А/445 тушаалын дагуу хог хаягдлыг түр хадгалах цэгийг битүү хогийн цэгийн хоолны үлдэгдэл, ахуйн хог хаягдлыг хадгалах савыг битүүмжлэн элдэв идэшт шувууд орох боломжгүй болгосон. Хогийн цэгт болон ойр орчимд нь элдэв идэшт буюу хэрээний төрлийн шувуу бүртгэгдээгүй.<br><i>Хавсралт 21. Хүнсний хаягдлын цэг орчмын ажиглалтын бүртгэл</i>  | -      |
|   |        | Элдэв идэшт шувуудын ажиглалтын бүртгэл хөтлөх  | Биологийн төрөл зүйлийг хамгаалах  | Тусгай зөвшөөрлийн талбай дотор хэрээнийхэн овгийн хулан жороо 34 бодгаль, хар хэрээ 5 бодгаль, хон хэрээ 18 бодгаль бүртгэгдсэн.<br><i>Хавсралт 19. 2024 оны амьтны бүртгэл</i>   | -      |
| <b>ЕС. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>   |        |   |  |  |        |
| Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар Говийн их ДЦГ-ын А хэсгийн орчны бүс, Их Боглын БЦГ-т тархан амьдрах амьтад үргэж дайжих, хууль бус ан хийх |        | Их Богдын БЦГ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулах  | Уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны сургалт, зааварчилгаа, дотоод журам | Байгаль орчин, аялал жуулчлын яамтай “Хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 05 дугаар сарын 31-нд байгуулан, санамж бичигт тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/71 тушаалын дагуу Их Богдын байгалийн цогцолборт газар нутгаар дайран өнгөрсний хураамжийг тээврийн хэрэгсэл бүр улирал тутам төлсөн.<br>Тус хамгаалалттай захиргаатай санамж бичиг байгуулах ажлыг БОАЖЯ-тай санамж бичиг байгуулсан, тусгай хамгаалалттай газар нутгаар дайран өнгөрсөн хураамжийг төлсөн, мод тарих ажлыг ТЭЗҮ батлагдсны дараа гэрээ байгуулан гүйцэтгэхээр аман байдлаар тохиролцсон. | 80,000 |
| <b>АРАВ. ДУУ ШУУГИАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>   |        |   |  |  |        |
| Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугианы нөлөөлөх үүсэх ба ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй   |        | Хэт өндөр дуу шуугиантай (80dBA-аас дээш) орчинд ажилладаг ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл тогтмол ашиглуулах                     | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм                                | “OHSE.EM.302- Эрүүл ахуйн журам”-ын дагуу сар бүр орчны эрүүл ахуйн хэмжилт, дуу шуугианыг зориулалтын багажаар хэмжиж баталгаажуулан ажилладаг. Хэмжилтийн үр дүнгээр дуу шуугиан 80 дБ-ээс дээш ажлын байруудад тэмдэг тэмдэглэгээ, “OHSE.EM. 417-Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох ашиглах журам”-ын дагуу сонсгол хамгаалах хэрэгслийг байршуулан ажилладаг.<br>Чихний бөглөөг давхардсан тоогоор 428 ажилтанд олгосон, нөөцөнд 600 ш байна.   | -      |

|  |  |   |  |          |
|--|--|---|--|----------|
| <p>Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугиан үүсэж, ойролцоо орших нутгийн 1 малчин айлын тав тухад сөргөөр нөлөөлж болзошгүй.</p>            | <p>Энэ айл өвөлжөөндөө өвөлжиж байгаа үед сард 1 удаа дуу шуугианы хэмжилт хийх, үр дүнгээс хамааран давтамжийг өөрчлөх</p>          | <p>Санал гомдол шийдвэрлэх механизм</p> | <p>Төслийн нөлөөллийн бүсэд жилийн туршид айл нутаглаагүй.</p>   | <p>-</p> |
| <p><b>АРВАН НЭГ. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b></p>  |  |   |  |          |
| <p>Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох талбайн ойр нутаглаж буй малчин өрхүүдийн мал үүсгэсэн карьерт унан эрсдэж болзошгүй</p>                                | <p>Нутгийн иргэдэд уурхайн үйл ажиллагааны мэдээлэл өгч ажиллах</p>  | <p>Санал гомдол шийдвэрлэх механизм</p> | <p>2024 онд ОНХ-ны хэсгээс давхардсан тоогоор Шинэжинст сумын 100 гаран айл, өрхөөр зочилж, 6,7 дугаар саруудад ачаа тээврийн замыг иргэд хааж зогсоход Шинэжинст сумын 100 гаран иргэдэд төслийн талаар мэдээлэл хүргэсэн. Баянцагаан, Баацагаан сумын иргэдтэй 9 дүгээр сард хийсэн нэгдсэн уулзалтад оролцсон 120 гаран иргэнд төслийн талаар мэдээлэл өгч ажилласан байна. Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн тадлаарх мэдээллүүдийг “Баянхөндий төсөл” болон Шинэжинст сумын фэйсбүүк хуудсуудад байршуулснаар зорилтот бүлэгт төслийн талаарх бодит мэдээллийг 80 хувьтай хүргэж байна. Баянхонгор мэдээллийн төвөөр 1320 иргэнд мэдээлэл өгсөн.</p> | <p>-</p> |
| <p>Нутгийн иргэд Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлгүй байх, болон малчин иргэдийн хооронд маргаан үүсч болзошгүй</p> | <p>Төслийн мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэх</p>                    | <p>Санал гомдол шийдвэрлэх механизм</p> | <p>Тайлант хугацаанд 46 иргэнээс өргөдөл, хүсэлтийг хүлээн авч 40 өргөдөл хүсэлтийн дагуу шийдвэрлэсэн, үлдсэн 6 хүсэлтийг шийдвэрлэх шатанд явж байна.</p>  | <p>-</p> |
| <p>Нутгийн иргэд Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлгүй байх, болон малчин иргэдийн хооронд маргаан үүсч болзошгүй</p> | <p>Шинээр ажилд орж байгаа ажилчдад нутгийн иргэдтэй хүндэтгэлтэй харьцах зааварчилгааг ерөнхий зааварчилгаагаар дамжуулан олгох</p> | <p>Санал гомдол шийдвэрлэх механизм</p> | <p>Шинээр ажилд орж байгаа ажилтнуудад салбарын захиргааны албаны даргын баталсан “Шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр”-т тусгагдсан IMS.EM.04 Иргэд, хуулийн этгээд, сонирхогч талуудын өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, судлан бүртгэх журам, IMS.EM.08 Оролцоо, зөвшилцөл болон харилцаа зохицуулах журмуудад тусгагдсаны дагуу нутгийн иргэдтэй хүндэтгэлтэй харилцах талаар зааварчилгааг олгодог. Шинэ ажилтны сургалтад 10 дугаар сарын 27-ны байдлаар 535 ажилтан хамрагдсан.</p> <p><i>Хавсралт 22. Шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр</i></p>  | <p>-</p> |

|  |  |  |  |                               |
|--|--|--|--|-------------------------------|
| <p>Шинэжинст сумын иргэдээс ажилд орох хүсэлтэй боловч боловсрол, ажлын туршлага хангалтгүйгээс орж чадахгүй байж болзошгүй</p>    | <p>Баянхөндий төсөлд ажиллах хүсэлтэй орон нутгийн иргэдийг бүртгэх, ажлын байрны шаардлага хангасан иргэдийг төслийн хүчин чадалд тохируулан ажлын байраар хангах</p> | <p>Хүний нөөцийн бодлого</p>                         | <p>Эрдэнэ Монгол ХХК-ний Баянхонгор салбар өнөөдрийн байдлаар 74 үндсэн ажилтантай ба үүний 21 нь Баянхонгор аймгийн харьяат иргэд байна. Салбар нь 2024 онд нийт 37 шинэ ажилтан авсан ба үүний 34 нь инженер болон нарийн мэргэжлийн ажлын байр байсан.<br/>Хүнд машин механизмын операторын сургалтыг Ухаа худаг уурхайд үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Тайлант онд нэг ээлж буюу 20 иргэнийг сургахаас гадна хувиараа сургалтанд хамрагдах хүсэлтэй Баянхонгор аймгийн 10 иргэн сургалтад хамрагдсан. Эдгээр иргэд нь Баянхөндий төсөлд ажиллах юм.<br/>Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хаврын тарилтын үеэр Шинэжинст сумын 10 иргэнийг нэг сарын хугацаанд түр гэрээгээр ажиллуулсан.<br/>Баянхөндий төслийн үйл ажиллагаанд туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа 20 аж ахуйн нэгжийн 1087 ажилтны 374 буюу 34 хувь Баянхонгор аймгийн иргэд байна.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> |
|  | <p>Шинээр ажлын байр зарлагдсан тухай бүрт зарыг <a href="http://www.zangia.mn">www.zangia.mn</a> сайтад байршуулах</p>  | <p>Хүний нөөцийн бодлого</p>                         | <p>Бид нээлттэй ажлын байрыг иргэдэд олон сувгаар мэдээлэл дамжуулах зорилгоор Баянхөндий төсөл Facebook page, <a href="http://www.erdene.mn">www.erdene.mn</a>, <a href="http://www.zangia.mn">www.zangia.mn</a>, <a href="http://www.linkedin.com">www.linkedin.com</a>, Баянхонгор аймгийн хөдөлмөр халамжийн газар, Шинэжинст сумын хөдөлмөр халамжийн байцаагч, Шинэжинст сумын Facebook групп, Шинэжинст сум болон Баянхонгор аймгийн төлөөлөгчийн газар байрлах мэдээллийн самбар зэрэг дээр байршуулан ажиллаж байна.</p>  | <p>Үйл ажиллагааны зардал</p> |
| <p>Орон нутагт уул уурхайтай холбоотой хүн амын хөдөлгөөн нэмэгдэхийн зэрэгцээгээр архидалт, гэмт хэргийн гаралт өсч болзошгүй</p> | <p>Төслийн талбайд архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох зааварчилгааг “Талбайн ерөнхий зааварчилгаа”-аар дамжуулан олгох</p>                                  | <p>Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм</p> | <p>“OHSE.EM.403.01 Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг илрүүлэх сорил хийх заавар”-ын дагуу Эрдэнэ Монгол ХХК, түүний туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн бүх ажилтнууд өглөө бүр ажилд гарахын өмнө амьсгал дахь алкохоголийн тест хийлгэдэг, сард дунджаар 20,460 удаа амьсгал дахь согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах тест хийгддэг.</p>   | <p>Үйл ажиллагааны зардал</p> |



#### 4.7.1. Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбайд барилга угсралтын үе шат үргэлжлэн явагдаж байна.




**Зураг 9. Барилга угсралтын үйл явц**



**Зураг 10. Үндсэн кэмийн барилгын үйл явц**

Барилга барих үйл явцтай холбоотойгоор хөрсөн бүрхэвч, ургамлын аймагт үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, нөхөн сэргээлтийг оновчтой төлөвлөх зорилгоор газар шорооны ажлыг компанийн дотоод журмаар зохицуулан, мөрдлөг болгон ажиллаж эхэлсэн. Тухайн газар шорооны ажлыг эхлэхээс өмнө тухайн талбай дахь ургамлын

бичиглэлийг хийж, нөхөн сэргээлтийг төлөвлөснөөр ажил эхлүүлэх зөвшөөрлийн дагуу эхлүүлж, шимт хөрсийг хуулдаг. Шимт хөрс хуулалтын үзлэгийг байгаль орчны хэсгээр хийлгэж, хангалттай гэж үзсэн тохиолдолд төлөвлөгөөт ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэдэг. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл тус бүрт тухайн ажлын талаарх мэдээлэл, байршлыг харуулсан .dwg болон ажил эхлэхээс өмнөх болон ажил гүйцэтгэсний дараах байдлыг харуулсан фото зургийг агуулсан хавтсыг үүсгэж Sharepoint-д байршуулдаг.



**Зураг 11. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн мэдээллийн сан**

Төслийн талбарт ажиллаж байгаа нийт ажилтнуудын байгаль орчны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, байгаль хамгаалах зөв дадал хэвшилтэй болгох зорилгоор талбайн ерөнхий зааварчилгаа, шинэ ажилтны сургалтаар дамжуулан мэдлэг олгож, зааварчилгаа өгөхөөс гадна дараах агуулгуудаар сургалтын материал бэлтгэн хагас жил тутам сургалтыг давтан ордог. Үүнд:

1. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл
2. Ус хэмнэх зөвлөмж
3. Хог хаягдлын менежмент
4. Хог хаягдал ангилан ялгалт
5. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах нь
6. Баянхөндий төсөл, хүрээлэн буй орчин ургамал хамгаалал
7. Биологийн олон янз байдал, амьтан хамгаалал
8. Говийн гайхамшигт - 6
9. Археологи палеонтологийн олдвор олдсон, илэрсэн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

Дээрх 9 агуулга бүхий сургалтад давхардсан тоогоор төслийн талбайд ажиллаж байгаа 2000 гаран ажилтан хамрагдсан.






**Зураг 12. Байгаль хамгаалах сургалт зохион байгуулж байгаа байдал**

Төслийн талбайд ирж байгаа болон талбайгаас явж байгаа тээврийн хэрэгслүүдэд хориотой амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж байгаа байдалд тогтмол хяналт тавьж, үзлэгийн хуудсаар баталгаажуулдаг.

Замын хөдөлгөөнд оролцохдоо зөвхөн тогтоосон замаар зорчдог ба салаа зам үүсгэхийг хориглодог. Тусгай зөвшөөрлийн талбайд болон тээврийн зам дагуу шаардлагатай цэгүүдэд зохих замын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан ба компанийн гүйцэтгэх захирлын баталсан “OHSE.EM-101 Замын хөдөлгөөний журам”-аар төслийн талбай дахь замын хөдөлгөөнийг зохицуулан, журмыг мөрдлөг болгон хөдөлгөөнд оролцож байна. Төслийн талбайд тогтмол ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүдэд ХАБ-ын хэсэг холбогдох инженерүүдтэй хамтран тээврийн хэрэгслийн үзлэгийг гүйцэтгэж нэгдсэн бүртгэл оруулан, стикер дугаар олгодог. Төслийн талбайд 155 ш тээврийн хэрэгсэлд стикер дугаар буюу төслийн талбайд замын хөдөлгөөнд оролцох эрхийг олгосон.



**Зураг 13. Төслийн талбай доторх замын маршрут**

#### 4.7.2. Нийгэм, эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл

Шинэжинст сумын 100 гаран өрхөөр зочилж, 2 удаа ачаа тээврийг зогсоосонтой холбоотойгоор иргэдтэй хийсэн уулзалтуудын үеэр төслийн үйл ажиллагааны талаар танилцуулсан.

Нээлттэй ажлын байрыг иргэдэд олон сувгаар мэдээлэл дамжуулах зорилгоор Баянхөндий төсөл Facebook page, [www.erdene.mn](http://www.erdene.mn), [www.zangia.mn](http://www.zangia.mn), [www.linkedin.com](http://www.linkedin.com),

Баянхонгор аймгийн хөдөлмөр халамжийн газар, Шинэжинст сумын хөдөлмөр халамжийн байцаагч, Шинэжинст сумын Facebook групп, Шинэжинст сум болон Баянхонгор аймгийн төлөөлөгчийн газар байрлах мэдээллийн самбар зэрэг дээр байршуулан ажиллаж хүний нөөцийг бүрдүүлж байна. Эрдэнэ Монгол ХХК-ний Баянхонгор салбар өнөөдрийн байдлаар 74 үндсэн ажилтантай ба үүний 21 нь Баянхонгор аймгийн харъяат иргэд байна. Салбар нь 2024 онд нийт 37 шинэ ажилтан авсан ба үүний 34 нь инженер болон нарийн мэргэжлийн ажлын байр байсан. Баянхөндий төслийн үйл ажиллагаанд туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа 20 аж ахуйн нэгжийн 1087 ажилтны 374 буюу 34 хувь Баянхонгор аймгийн иргэд байна. Хүнд машин механизмын операторын сургалтыг Ухаа худаг уурхайд үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Тайлант хугацаанд гурван ээлж буюу 64 иргэнийг сургахаас гадна хувиараа сургалтанд хамрагдах хүсэлтэй Баянхонгор аймгийн 10 иргэн сургалтад хамрагдсан. Эдгээр иргэд нь Баянхөндий төсөлд ажиллах юм.

Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хаврын тарилтын үеэр Шинэжинст сумын 10 иргэнийг нэг сарын хугацаанд түр гэрээгээр ажиллуулсан. Иргэдээс ирсэн өргөдөл, хүсэлтийн дагуу Шинэжинст сумын нутаг дэвсгэрт бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Ханан, Залаа, Бага сухайтын гүн өрмийн худгуудыг усны мэргэжлийн байгууллагаар шинээр гаргуулан суманд хүлээлгэн өгсөн.



Зураг 14. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэв

#### 4.8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн талбайд нөхөн сэргээх арга хэмжээ авч, газрын эвдрэлийг хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлздэг. “Баянхөндий” төслийн барилгажилт, уурхайн олборлолтын үе шатуудад эвдрэх газрын хэмжээг хамгийн бага байлгах үүднээс төслийн талбайд газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийг хэрэгжүүлж эхэлсэн. Түүнчлэн, нөхөн сэргээлтийн ажилд бэлдэх үүднээс байгалийн ургамал үржүүлгийн газар байгуулж, тодохой хэмжээний ургамлын үр бэлдэж, үрээр үржүүлэх, тарьц суулгац бэлдэх ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Мөн геологийн хайгуулын цооног өрөмдсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж, анхны төрхөнд ойртуулахыг зорьсон.

**Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт**

| Нөхөн сэргээлтийн зорилт   | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ   | Тоо хэмжээ | Баримтласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага                        | Хэрэгжүүлсэн арга хэмжээ   | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|--|---|------------|---|--|---------------------------------|
| Шимт хөрсийг овоолгод тогтвортой байршуулж, нөхөн сэргээлтэд ашиглахад бэлтгэх | Төслийн барилгажилтын үед 5.8 га талбайгаас 0.3 м зузаантай хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг, талбай руу тээвэрлэх, овоолго үүсгэх | 17,400     | MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт | Шимт хөрсний овоолгыг “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008” стандартын дагуу 5 хүртэл метрийн өндөртэй үүсгэж байна. Төслийн хэмжээнд 2 талбайд шимт хөрсний овоолгыг үүсгэсэн, уурхайн бүсэд 19409.78 кв.м талбайд 40498.2 куб.м, ажилчдын кэмп орчимд 5412.21 кв.м талбайд 3557.29 куб.м шимт хөрсний овоолгыг үүсгээд байна.  | Үйл ажиллагааны зардал          |
|  | Шимт хөрсний овоолгын хөрсний үржил, шимт чанарыг алдагдуулахгүй байх усалгаа хийх  | 2          |   | Шимт хөрсний овоолгын үржил шимт чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор 5 дугаар сарын 09 болон 9 дүгээр сарын 18-ны өдрүүдэд Монруд ХХК-ийн 10 куб.м багтаамжтай машинаар усалгааг гүйцэтгэсэн.  | Үйл ажиллагааны зардал          |
| Ургамал үржүүлгийн газрыг бэхжүүлэх  | Мод тарих усалгааны арга технологийг судлах   | 1          | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн   | Тайванийн мод усалгааны эко хувинг Цы Синь органик хөдөө аж ахуйн сан болон Рэн Жоу компани хамтран зохион бүтээсэн бөгөөд бид Тайванийн далайн эргээс өндөр уулс хүртэл төрөл бүрийн доройтолтой, ургамал ургахад хүндрэлтэй болсон газруудад энэхүү хувинг ашиглан бэрхшээлийг давж Тайваньдаа нийт 1,1 сая гаруй модыг амжилттай тарьж ургуулжээ. Харин Монголд, Хязгааргүй байгаль сан Монголын тал хээр болон цөлжилттэй бүс нутагт энэхүү эко хувинг ашиглаж тарьсны үр дүнд модны амьдрах | -                               |

|   |   |        |   |   |                        |
|---|---|--------|---|---|------------------------|
|   |   |        |   | <p>чадвар дунджаар 80%-иас дээш үзүүлэлттэй байна.Энэ онд Эхийн голд тус хувинг ашиглан тарьсан модны амьдралтын хувь 90 хувь байна. Ирэх онд уг хувингаас 1000 ш худалдаж авахаар төлөвлөсөн.</p> <p><i>Хавсралт 23. Хувингийн танилцуулга</i></p>   |                        |
|   | Нутгийн ургамлын үрээр тариалалт хийх   | 10,000 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025  | <p>Үрээр заг, хайлаас, шар хотир, хармаг, агч, жигд, шар хуайс, бүйлс, тоорой мөчрөөр сухай нийт 72158 ш үрсэлгээг тарьж, 54176 ш суулгацыг ургуулсан. Өмнөх онд тариалсан үрсэлгээнээс 840 ш суулгацыг ургамал үржүүлгийн талбайд шилжүүлэн суулгаж, Шинэжинст суманд гэрээ байгуулан мод тарих ажлыг гүйцэтгэж байгаа иргэдэд 5850 ш суулгацыг шилжүүлэн өгсөн.</p>   | Үйл ажиллагааны зардал |
|   | Нутгийн ургамлын үр түүх  | 30     | Байгалийн ургамлын тухай хууль 13.3   | <p>Дараа жилүүдийн тариалалтад хэрэглэх, нутгийн ургамлын үрийн сан бүрдүүлэх, нөхөн сэргээлтэд нутгийн ургамал хэрэглэх зорилгоор шар хотирын 6.7 кг, хайлаас 5 кг, лидэр 9 кг, чихэр өвс 8 кг, Монгол буйлс 7 кг, тоорой 7 кг үр түүсэн.</p>  | Үйл ажиллагааны зардал |
| Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон талбайг нөхөн сэргээх | Төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн техникийн нөхөн сэргээлт хийх | 10     | “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх | <p>Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын саналын дагуу Баян-Өндөр сумын Идрэнгийн нуруунд 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр газар дээр нь хэмжилт хийх үед нутгийн иргэд нөхөн сэргээлт хийлгэхгүй гэсэн. Иймд Өлзийт сумын Байн ам 2-р багийн Ар өнц гэх газарт 10.52 га талбайд Баянхонгор аймгийн харъяат Хатан шижир ХХК-аар гэрээлэн гүйцэтгүүлж, техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн.</p> <p><i>Хавсралт 24. Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн акт</i></p> | 62,090.0               |



|   |  |   |  |  |                               |
|---|--|---|--|--|-------------------------------|
| <p>Газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах</p> | <p>Цооног өрөмдсөн, суваг малтсан, газар шорооны түр ажил хийгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлтийн стандартыг баримтлан анхны төрхөд ойртуулах</p> | <p>Хаасан газар шорооны ажлын зөвшөөрлийн тоогоор</p> | <p>“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008”</p> | <p>Хөндий талбайд 10 дугаар сарын 20-ны байдлаар хайгуулын зорилгоор 6 цооног 950 т.м Баянхөндий орд дээр гүйцээх буюу нарийвчилсан ашиглалтын үеийн хайгуулын ажлын хүрээнд нийт 99 цооног өрөмдсөн. Цооног өрөмдсөн тухай бүрт, Баянхөндий кэмийн бохир ус тунгаагуурын талбай өргөтгөх, сүлжээний цамхагаас уурхайн үндсэн кэмийн барилгын талбайд байрлах генераторт тэжээлийн тас татах, 13-р постонд цахилгааны утас татах 6 ш газар шорооны ажлыг зөвшөөрлийн дагуу гүйцэтгэж, техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэхийг эрхэмлэн, анхны төрхөд ойртуулж, ойр орчмын хог хаягдлыг бүрэн цэвэрлэсэн.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> |
|---|--|---|--|--|-------------------------------|



Шимт хөрсний овоолгыг стандарт болон БОННУ-д тусгагдсны дагуу 5 хүртэл метрийн өндөртэй, 60м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэж байна. Барилгын үе шатанд 125843 м<sup>3</sup> шимт хөрс хуулагдахаас 29323 м<sup>3</sup> шимт хөрсийг овоолгод байршуулсан.



**Зураг 15. Шимт хөрсний овоолго**

Хөрсний овоолгыг 5 хүртэл метрийн өндөртэй, 60 м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэснээр хөрсөн дэх үрээр ургамал ургах нөхцлийг бүрдүүлсэн. Хуулагдах шимт хөрс хуулагдаж дуусаагүй тул хуулагдсан байгаа шимт хөрсний үржил шимт чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор усалгааг 5 болон 9 дүгээр саруудад хийсэн.



**Зураг 16. Шимт хөрсний овоолго дээр усалгаа хийж байгаа байдал**


Байгалийн ургамал үржүүлгийн газрыг 2 га талбайд 2022 онд байгуулж, тарьц суулгац бэлтгэж эхэлсэн. Энэ онд ургамал үржүүлгийн талбайн тохижилтын ажлаас гадна нутгийн

ургамлын үрээр 72,178 ш бортогонд тарилт хийснээс намрын тооллогоор 54,176 ш бортогонд тарьц ургац байна.

Өмнөх жилүүдэд бэлдсэн суулгацыг байгальд шилжүүлэн суулгах ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ онд уурхайн кэмп рүү ирэх дотоод замын хойд талд 12 эгнээгээр 60 ш загийн суулгацыг шилжүүлсэн суулгасан. Бэлдсэн тарьц болон шилжүүлсэн суулгацын амьдралтын хувийг ирэх хавар үнэлнэ.



Зураг 17. Үрээр тарьсан заг, жигдний ургалтын байдал



Зураг 18. Зам дагуу шилжүүлэн тарилт хийсэн байдал

Хүснэгт 12. Тариалалтын мэдээ, 2024 оны

| №  | Тарьц суулгац, нөмөрлөгч модны нэр | Нэгж | Бортогонд үрээр /хавар/ | Бортоготой тарьц, Намрын тооллого | Салхины нөмөрлөгч хашлагаар тарьсан | Мод тарьсан иргэдэд шилжүүлсэн бортоготой суулгац |
|----|------------------------------------|------|-------------------------|-----------------------------------|-------------------------------------|---|
| 1. | Заг                                | ш    | 28,607                  | 20,050                            | 391                                 | 1,851   |
| 2. | Сухай                              | ш    | 11,317                  | 9,110                             | 1,800                               | 2,715   |
| 3. | Сибир хармаг                       | ш    | 841                     | 218                               |                                     |   |
| 4. | Үнэгэн сүүлэхэй лидэр              | ш    | 1,906                   | 1430                              |                                     |   |



|             |                            |          |               |               |              |              |
|-------------|----------------------------|----------|---------------|---------------|--------------|--------------|
| 5.          | Шар хотир модот            | ш        | 2,936         | 2,342         |              |              |
| 6.          | Мөнгөлөг жигд              | ш        | 2,351         | 1,985         | 18           |              |
| 7.          | Хайлаас                    | ш        | 16,560        | 12,856        | 469          | 784          |
| 8.          | Элдэв навчит улиас/ Тоорой | ш        | 4,220         | 3,825         |              |              |
| 9.          | Урал чихэр өвс             | ш        | 1,648         | 1,560         |              |              |
| 10.         | Монгол бүйлс               | ш        | 1,792         | 800           | 30           |              |
| 11.         | Мөнгөлөг улиас             | ш        | -             | -             | 150          |              |
| 12.         | Агч                        | ш        | -             | -             | 2            |              |
| <b>Нийт</b> |                            | <b>ш</b> | <b>72,178</b> | <b>54,176</b> | <b>2,860</b> | <b>5,350</b> |

#### 4.9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

##### 4.9.1. Биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн бүс нутгийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэхийг зорилготой ажиллаж байгаа билээ. Энэхүү зорилгодоо уурхайн хаалтын үед хүрсэн байхаар зорьж байгаа хэдий ч төсөл хэрэгжих хугацаанд аль болох эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд ГИДЦГ-ын А хэсгийн хамгаалалтын захиргаа, Шинэжинст сумын байгаль хамгаалагч нартай хамтран туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн хамтаар биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Биотехникийн арга хэмжээний хүрээнд Сэгс Цагаан Богд, Жинстийн нуруу зэрэг газруудад 190 боодол өвсийг тараан байрлуулж, 2600 кг хорголжин тэжээлийг мазаалайн тэжээлийн савнуудад тараан байршуулсан.

Мөн 2017 онд Цагаан бургасны баянбүрдэд байрлуулсан мазаалайн тэжээлийн савыг сэргээн будсан ба Цагаан дэрс гэх газарт хоёрдогч түүхий эд ашиглан хийсэн мазаалайн тэжээлийн савыг байрлуулсан.



Зураг 19. Мазаалайн тэжээлийн сав



**Зураг 20. Өвс, тэжээл тавьж буй байдал**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай 05 дугаар сарын 31-нд “Хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулан “SaveMazaalai” уриатайгаар мазаалай баавгай хамгааллын ажлуудыг хэрэгжүүлж байна. Санамж бичгийн хүрээнд “Монгол мазаалай” контентийг Хүрээлэн төсөлтэй хамтран бүтээж, нийтийн хүртээл болгосон. Компанийн facebook хуудсаар “Мазаалайгаа магъя” пост бичих уралдааныг зарлаж, шилдгүүдээ шалгаруулсан. Мөн ургамал үржүүлгийн талбайд 100 ш бортогонд бажууныг үрээр тарих туршилтыг 8 дугаар сараас эхлүүлж 20 ш бортогонд үрсэлгээнүүд цухуйсныг өвөлжилтөд бэлтгэсэн.

#### **4.9.2. Дүйцүүлэн хамгааллын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд**

МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг дэмжин 2030 он гэхэд 1 сая мод тарих ажлыг төлөвлөсөн. Өмнөх жилүүдэд бэлдсэн суулгацыг байгальд шилжүүлэн суулгах ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ онд уурхайн кэмп рүү ирэх дотоод замын хойд талд 12 эгнээгээр 60 ш загийн суулгацыг шилжүүлсэн суулгасан. Бэлдсэн тарьц болон шилжүүлсэн суулгнацын амьдралтын хувийг ирэх хавар үнэлнэ. Тэрбум мод хөтөлбөрийг нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд элсний нүүдлийг зогсоох, тарьсан ойн зурвас байгуулах зорилгоор нутгийн иргэдтэй хамтран Шинэжинст сумын:

- Сумын төвд 0.5 га-д хайлаас 1258 ш, заг 168 ш, сухай 104 ш нийт 1530 ш мод.
- Эрдэнэшанд багийн Хүрэнгийн үзүүр гэх газарт 1 га талбайд хайлаас 887 ш, заг 440 ш, сухай 173 ш нийт 1500 ш мод.
- Эрдэнэшанд багийн төвд 1 га талбайд хайлаас 838 ш, заг 296 ш, сухай 133 ш, үхрийн нүд 10 ш нийт 1277 ш мод.
- Уртын гол багийн төвд 0.3 га талбайд хайлаас 492 ш, заг 115 ш, сухай 64 ш, үхрийн нүд 9 ш нийт 680 ш мод
- Эхийн голд 2 га талбайд заг 1300 ш, сухай 2415 ш нийт 3715 ш мод тарьсан.

Нутгийн иргэдтэй мод тарих гэрээг 3 жилийн хугацаатайгаар байгуулсан бөгөөд дараагийн жилүүдэд талбайн хэмжээг сунгах болон тарих модны тоог нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулна.



**Зураг 21. Нутгийн иргэдтэй хамтран тарьсан модны ургалтын байдал**

Баян-өндөр сумын Идрэн багийн нутаг Ламын тоорой гэх газарт зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор хөв байгуулах ажлыг Баялаг говь ХХК-тай хамтран гүйцэтгэсэн. Ламын тооройн худагт цооногийг хамгаалах зорилгоор 0.7 м-ийн диаметртэй пластик кольцо, худагт 6 м-ийн гүнд насосыг суулгасан ба 9 куб м багтаамжтай хөвийг 15 см зузаантай бетон цутгаж байгуулсан ба нарны толийг худгаас 3 м зайд байрлуулж, толийг 1.2 м өндөртэй хамгаалалтын хашаагаар амьтнаас хамгаалсан.



**Зураг 22. Ламын тооройн хөв**



**Хүснэгт 13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| Нөхөн сэргээлтийн зорилт                       | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ                | Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага                 | Тоо хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ   | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|--|--|--|------------|--|---------------------------------|
| Байгалийн амьдрах орчныг нөхөн сэргээх         | Тарьц, суулгац бэлдэх                        | МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод тарих" үндэсний хөдөлгөөн   | 10,000     | Үрээр заг, хайлаас, шар хотир, хармаг, агч, жигд, шар хуайс, бүйлс, тоорой мөчрөөр сухай нийт 72158 ш үрсэлгээг тарьж, 54176 ш суулгацыг ургуулсан. Өмнөх онд тариалсан үрсэлгээнээс 840 ш суулгацыг ургамал үржүүлгийн талбайд шилжүүлэн суулгаж, Шинэжинст суманд гэрээ байгуулан мод тарих ажлыг гүйцэтгэж байгаа иргэдэд 5850 ш суулгацыг шилжүүлэн өгсөн.   | 63,705.0                        |
| Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах | Нутгийн иргэдтэй хамтран мод тарих           |  | 3,000      | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд нутгийн иргэдийг дэмжих, мод тарих, таримал ой бүхий зурвас байгуулах зорилгоор Шинэжинст сумын 4 иргэн, ГИДЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран мод тарихад шаардлагатай тарьц суулгац, хашаа, услалтын систем, генератороор бүрэн хангаж 5 талбайд нийт 8702 ш мод 88.2 хувийн ургалттай байна. Шинэжинст сумын төвд 1530 ш, Хүрэнгийн үзүүрт 1500 ш, Эрдэнешанд багийн төвд 1277 ш, Уртын гол багийн төвд 680 ш, Эхийн голд 3715 ш мод ургаж байна.   | 92,915.3                        |
|  | Ламын тооройн худгийг түшиглэн хөв байгуулах | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 9.6 дугаар заалт | 1          | Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн багийн Ламын тооройн худагт нарны өргүүр байрлуулан хөв байгуулах ажлыг Баялаг говь ХХК-тай гэрээлэн гүйцэтгүүлсэн. Ламын тооройн худагт цооногийг хамгаалах зорилгоор 0.7 м-ийн диаметртэй пластик кольцо, худагт 6м-ийн гүнд насосыг суулгасан ба 9 куб м багтаамжтай хөвийг 15 см зузаантай бетон цутгаж байгуулсан ба нарны толийг худгаас 3 м зайд байрлуулж, толийг 1.2 м өндөртэй хамгаалалтын хашаагаар амьтнаас хамгаалсан.<br><i>Хавсралт 25. Ламын тооройн худгийг тохижуулсан ажлын тайлан</i> | 9,900.0                         |



#### 4.10. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

Баянхөндий хээрийн ангийг тохижуулах, цэцэрлэгжүүлэх ажлын хүрээнд гэрүүд, оффис, гал тогоо, ариун цэврийн өрөө хооронд хайрган замыг гаргасан ба оффис, амралтын өрөө, ариун цэврийн өрөө, амралтын өрөөний урд талд өмнөх жилүүдэд үрээр тарьсан заг, хайлаас, мөчрөөр тарьсан сухай, суулгацаар тарьсан саваа улиас, тоорой ургаж байна. Төслийн оффисын хойд талд 50 ш хайлаас, яаралтай тусламжийн цэгийн урд талын цэцгийн мандалд 30ш мандлын цэцэг тарьсан.



Зураг 23. Кэмийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт

#### Хүснэгт 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

| Нөхөн сэргээлтийн зорилт                                    | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ                             | Тоо хэмжээ | Баримтласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага | Хэрэгжүүлсэн арга хэмжээ  | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|---|---|------------|--|---|---------------------------------|
| Хээрийн ангийн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ | Тариалсан суулгацыг арчилж ургуулах, нэг наст цэцэг тарих | 60         | Газрын тухай хууль 56.6                                    | Баянхөндий хээрийн ангид үрээр энхэлгэ, мөлхөө цэцгүүдийг тарьсан. Урьд жилүүдэд тарвсан модыг услаг, арчлах ажлууд хийгдсэн. |                                 |

#### 4.11. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Д.Баасандаш (1.9 км), Б.Ганбат (2.8 км), П.Нямсүрэн (3.2 км) нарын өвөлжөөний газар хамгийн ойр байршдаг. Дээрх малчин өрхүүд нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд тайлант хугацаанд нутаглаагүй хэдий ч төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс барилга угсралтын үе шатанд тухайн газруудад дуу шуугиан болон салхины хурдыг сард 1 удаагийн давтамжтай хэмжсэн.

#### Хүснэгт 15. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Нөлөөлөлд өртөх иргэд  | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ   | Баримтласан стандарт, аргачлал   | Хэрэгжүүлсэн арга хэмжээ  | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|--|---|--|---|---------------------------------|
| Барилга барих үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, тоосжилтоос ойролцоо нутаглаж буй малчин өрхийн гишүүдэд тавгүй байдал үүсгэж болзошгүй | Уурхайн үйл ажиллагаанаас буй дуу чимээ, тоосжилт нь ойролцоох өвөлжөөнүүдийн орчимд агаарын чанарын стандарт хэмжээнд байгаа эсэхийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тодорхойлж, шаардлагатай тохиолдолд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх. | Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2021 он | Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Малчин өрхүүд нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд энэ онд эзэмшлийн газартаа болон төслийн талбайн ойролцоо айлууд нутаглаагүй. | -                               |

#### 4.12. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёл өв олох магадлалтай. Хэрэв барилгын болон үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд газар шорооны ажлын үйл ажиллагааг түр зогсоож дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Барилгын ажлын явцад өмнө нь судалж тогтоож чадаагүй палеонтологи болон археологийн үнэт олдвор илэрвэл илэрсэн даруйд ажлаа зогсоож, олдворын талаар сум/аймгийн Засаг даргад мэдэгдэнэ.
- Бүртгэсэн соёлын өв, түүхийн үнэт олдворын эргэн тойронд эрх бүхий байгууллагын зөвлөмжийн дагуу хамгаалалтын бүс байгуулах ба хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий байгууллага бүртгэгдсэн тэдгээр зүйлсийг нүүлгэн шилжүүлнэ.
- Чухал ач холбогдол бүхий түүх соёлын олдвор, үнэт зүйлс олдсон тохиолдолд зөвөөрлөнө. Ингэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралт “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ыг баримтална.
- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

**Хүснэгт 16. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд   | Хамгаалах арга хэмжээ   | Баримтласан стандарт, аргачлал  | Хэрэгжүүлсэн арга хэмжээ   | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|---|---|---|--|---------------------------------|
| Газар шорооны ажлын үед том оврын техник хэрэгслээр хөрс хуулах, суваг шуудуу ухах зэрэг ажил хийгдэх явцад өмнөх судалгааны явцад илрээгүй, хөрсөнд хадгалагдан үлдсэн байж болзошгүй археологи, палеонтологийн олдвор санамсаргүй байдлаар тохиолдож, нөлөөлөлд өртөх | Археологи, палентлогийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх зааварчилгааг туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд өгөх       | “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Археологи, палеонтологийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх журам | Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёл өв олох магадлалтай учраас үйл ажиллагааны явцад олдвор илэрсэн олдсон тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалтыг 1 дүгээр сарын 13-нд ерөнхий гүйцэтгэгчийн 91, 6 дугаар сарын 02-нд М-Артор ХХК-ийн 11 ажилтанд зохион байгуулсан ба талбайн ерөнхий зааварчилгаагаар дамжуулан нийт ажилтнуудад олгодог.<br>Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Шинэжинст сумын Цагаан хаалганы рашааны эхийг хамгаалах ажлын хүрээнд Рашааны талаарх мэдээлэл бүхий самбар, рашааны эхээс ус ууж байгаа зэрлэг ан амьтадыг хянах зорилгоор дөлгөөн мэдрэгчтэй хяналтын камер 2 ш суурилуулсан.<br>Мөн Хавсралт 18. Сургалтын материал, бүртгэл | 1,807                           |
|   | Олдвор илэрсэн тохиолдолд орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, тусалцаа үзүүлэн хамтарч ажиллах | Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 27.8                       | Барилга угсралтын үе шатанд болон хайгуулын өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэхэд ямар нэг археологи палентлогийн олдвор олноогүй.   | -                               |

#### 4.13. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, хамгаалалтын асуудалтай холбоотой эрсдлүүдийг үнэлж, бууруулах журам, зааварчилгаанд дэлгэрэнгүй заасан байдаг ба түүнтэй холбоотой хариуцлага, мониторинг, үнэлгээний зохицуулалтыг тодорхойлсон байдаг.

Төслийн талбай, барилга угсралтын үйл явц, оффист ажлын байран дахь эрүүл мэнд, эрүүл ахуйн арга хандлагыг хэвшүүлэн сахиулдаг. Мөн ажлын байр, талбай нь компанийн бодлого, эрх зүйн шаардлагыг хангаж буй эсэхийг тогтмол хянан шалгадаг. Осол эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг доорх хүснэгтэд харууллаа.

**Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

| Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга  | Тоо хэмжээ        | Баримтласан стандарт, аргачлал   | Хэрэгжүүлсэн арга хэмжээ  | Зарцуулсан хөрөнгө (төгрөг) |
|--------------------------------------|--|-------------------|--|---|-----------------------------|
| Гал түймэр гарах                     | Гал унтраах дасгал сургууль тогтмол зохион байгуулах   | 2                 | Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4.  | Гал унтраах дадлага сургуулилтыг нийт 3 удаа зохион байгуулсан. Төслийн талбайд Гамшгаас хамгаалах команд штабын нэгдсэн дадлага сургуулилтыг Баянхонгор аймгийн Онцгой байдлын газартай хамтран 6 дугаар сарын 05-аас 08-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус дадлага сургуулалтад захилагч болон ерөнхий гүйцэтгэгчийн гэрээт аж ахуйн нэгжүүдийн албан хаагчид хамрагдсан.                             | Үйл ажиллагааны зардал      |
|                                      | Бүх ажлын талбайд галын дохиолол, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавих | Бүх ажлын байранд | Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3 барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног | Гал унтраах тусгай зориулалтын автомашин худалдан авсан. Аврагч жолооч албан тушаалд шинээр орон тоо гаргаж 2 ажилтан, онцгой байдлын ажилтан-1 ажиллаж байгаа ба гал унтраахад ашиглах иж бүрэн хувцас хэрэгсэл, гамшгийн үед хэрэглэх шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг тогтмол бэлэн байдалд байлгаж байна. Төслийн талбайн бүх хэсэгт аюулын гарцын байрлалыг заасан самбар галын дохиолол, гал | Үйл ажиллагааны зардал      |

|  |                        |  |   |  |                        |
|--|------------------------|--|---|--|------------------------|
|  |                        |  | төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах | унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг хийгдсэн.   |                        |
| Галын дохиолол, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах | Бүх гэр, ажлын байранд |  |   | <p>Галын сарай – 4 ш, кэмп бүрт дуут дохио 1 ш, утаа мэдрэгч - 48 ширхэг байршуулсан.</p> <p>Шланг                      Φ50/20 мм</p> <p>Муфьт                      Φ50/20 мм</p> <p>Гуулин хаалт              Φ51 мм</p> <p>Резбатай муфьт        Φ51 мм</p> <p>Энгийн хошуу            Φ51 мм</p> <p>Хомут                      Φ51 мм</p> <p>Галын гидрантын хайрцаг 60x50x20 см</p> <p>Галын 3 төрлийн хайрцаг байршуулсан.</p>  | Үйл ажиллагааны зардал |
| Гал унтраагуурыг зохих газруудад байрлуулах,                   | Бүх гэр, ажлын байранд |  |   | <p>ГАУС урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг 7 хоног бүрийн Лхагва гарагт хуваарийн дагуу хийдэг. ABC галын унтраагууруудыг гэр болон оффисийн түр байгууламжуудад байршуулсан. Техникийн өрөө болон хоолны заалуудад нийт 20 ширхэг тунгуус байршуулсан. Ерөнхий гүйцэтгэгчийн модуль кемп гал унтраагуурын нөөц 30 ширхэг, Баянхөндий кемп нөөцөнд ABC 35 кг нөөцөнд 5 ширхэг байна. Баянхөндий кемп дээр ABC галын унтраагуур 8 -15 кг 58 ширхэг, 35 кг галын унтраагуур 2 ширхэг 200 литрийн багтаамжтай усны танк 2 ширхэг. MCSP/ Модуль кемп-ABC төрлийн гал унтраагуур 91 ширхэг-25 м.кв талбайд 4 кг галын хор байрлуулсан, техникийн өрөөнд болон оффис, хоолны зааланд нийт 20 ш тунгуус байрлуулж, нөөцөнд 30 ш галын хор бэлэн байдлыг хангах зорилготой хадгалсан. Гал унтраах автомашин 1, тусгай зориулалтын хувцас- 5 хос, аврах багаж тоног төхөөрөмж, олс, харилцаа</p> | Үйл ажиллагааны зардал |

|                         |  |                                |  |   |                        |
|-------------------------|--|--------------------------------|--|---|------------------------|
|                         |  |                                |  | холбоо тасарсан үед ашиглах starlink явуулын автомашины төхөөрөмж 2 ш байнгын бэлэн байдалд байна.  |                        |
| Хүний эрүүл мэнд муудах | Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Анхан шатны тусламж үзүүлэх сургалт”-нд хамруулах                              | Сургалт авсан ажилчдын тоо     |  | Шинээр ирж буй ажилтнуудыг анхны тусламж, амилуулах суурь тусламжийн сургалтанд бүрэн хамруулж ажилладаг. Анхны тусламж болон эрүүл мэндийн сургалтыг 21 удаа 406 ажилтанд зохион байгуулсан зохион байгуулсан.   | -                      |
|                         | Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг урьдчилан сэргийлэх эмнэлгийн үзлэгт хамруулах                                  | Үзлэгт хамрагдсан ажилчдын тоо | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг | Шинэ ажилтнуудыг ажилд орохын өмнө эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг. Нийт ажилтныг эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалд хамруулсан. Ээлжээр ирсэн бүх ажилчдыг эмчийн үзлэгт оруулж ажилчны амин үзүүлэлт болон ажилд ирэх үеийн биеийн байдлыг хөтөлж тэмдэглэдэг ба шинээр ажилд орсон ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт орсон байх шаардлагыг тавьж ээлжээр ирэх үед үзлэгт орсон бичиг хуудсыг шалгаж ажилд тэнцсэн эсэхийг шалгаж ажилд гаргадаг. Ээлж солигдож ирсэн ажилчдын үзлэг -759, эрүүл мэндийн үзлэг -273, нөхөн сэргээх физик эмчилгээ - 182 удаа тус бүр хийсэн. | Үйл ажиллагааны зардал |
|                         | Хүний эрүүл мэнд муудахад анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бол ойр газар руу нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах | Шаардлагатай тохиолдолд        | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг | Ажилчдын эрүүл мэндийн асуудал гарахад шаардлагатай тоног төхөөрөмж бэлэн байдал бүрэн хангасан ба эмнэлгийн бүрэн тоноглогдсон машин яаралтай үеийн хэрэгцээнд ашиглахад бэлэн байдлыг хангасан. Өвчин эмгэгийн үед тээвэрлэлт хийх бэлэн байдлыг хангаж тээвэрлэлтийн журам болон бусад холбоотой дүрэм журмыг батлан мөрдөн ажиллаж байна. Ажлын байр, автомашинуудад анхны тусламжийн иж бүрдийг байршуулсан, сар бүр ажилтнуудад шаардлагатай эмийн нөөцийг  | Үйл ажиллагааны зардал |



|                       |  |                         |   |  |   |
|-----------------------|--|-------------------------|---|--|---|
|                       |  |                         |   | <p>бүрдүүлэн, тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.</p> <p>Нийт 18 ажилтныг дараагийн шатлалын эмнэлэгт нүүлгэн шилжүүлсэн байна.</p>  |   |
| Автомашины осол гарах | “Төслийн талбайд жолоодох эрх олгох сургалт зохион байгуулах, шалгалтанд тэнцсэн ажилтанд жолоодох эрх олгох | Шаардлагатай тохиолдолд | “Эрдэнэ Монгол” ХХК-ийн бодлого журмын гарын авлага | <p>Баянхөндий төслийн талбайд шинээр ирсэн ажилтан OHSE.EM-101 Замын хөдөлгөөний журмын сургалт болон төслийн талбайд жолоо барих эрх олгох онол болон дадлагын сургалтан хамрагдаж шалгалт өгч, шаардлагыг хангаж тэнцсэн тохиолдолд жолоо барих эрхийг үнэмлэхийг ХАБЭА-н хэсгээс олгодог. Автомашины осол гарсан үед шуурхай тусламж үзүүлэн ажиллах 1 гал унтраах машин, 1 түргэн тусламжийн машин, 1 ээлжинд 2 их эмч, 1 аврагч жолооч ажиллаж байна. Төслийн талбай болон төслийн талбайн гадуур хөдөлгөөнд оролцох үед осол гарсан үед тусламж үзүүлэн ажиллана.</p> <p>Төслийн талбайд жолоодох эрхтэй жолооч-244.</p> | - |

Гамшгийн үеийн бэлэн байдлын сургалтыг аймгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж, сургалтын үеэр төслийн талбайд ажиллаж байсан захиалагчийн болон ерөнхий гүйцэтгэгчийн албан хаагчид дадлага сургуулилалтад оролцсон.



7. Өгөгдсөн цагийн байдлын дагуу гадна тайлбайд үзүүлэх сургалтыг хийж, аврах бүлэг нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй, тус объект дээр, дуудлагаар ирэхэд газар хөдлөлтийн улмаас гал түймэр гарч үймээн самуун үүссэн байлаа.

**Зураг 24. Гамшгийн үеийн бэлэн байдлын сургуулилалт**

Бүх ажлын талбай, гэрүүдэд галын дохиолол, гал унтраагуур, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулсан.



Зураг 25. Мэдээллийн самбарууд, анхны тусламжийн хайрцаг

#### 4.14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

“Эрдэнэ Монгол” ХХК нь “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлын хэмжээг багасгах, түүнийг дахин ашиглах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулж, үлдсэн хог хаягдлыг хог хаягдлын цэгт хадгалж, хуванцар хог хаягдлыг пресслэгч машинаар шахаж, эзэлхүүнийг багасган хоёрдогч түүхий эд авах төвл нийлүүлж, үлдсэн энийн хог хаягдлыг аймгийн Засаг даргын 2023 оны “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай” А/728 захирамжийн дагуу устгаж байна.

“Шинэжинст сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй байгуулах хог хаягдлын гэрээ”-г 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдөр сумын Засаг даргатай байгуулсан.

Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад 103,1 сая төгрөг зарцуулсан ба дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Эдгээрт:


- Шинэжинст сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2024 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай” 102 дугаар тогтоолын дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж сар бүр 2,000,000 /хоёр сая/ төргөрийн хураамжийг гэрээ байгуулсан хугацаанаас төлж эхэлсэн.
- Энгийн хог хаягдлыг тээвэрлэх, устгах ажлыг гүйцэтгэх гэрээг Шинэжинст сумын “Диваажингийн үнсэлт” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.
- Тээврийн зам дагуу Баацагаан сумын Бунхан сайр, Шинэжинст сумын Үзүүр худаг гэх газруудад түр зогсоолыг шинээр байгуулсан. Түр зогсоолд энгийн болон хуванцарм хаягдлыг ангилан хаях хогийн савнууд, стандартын шаардлага хангасан зөөврийн 00 суурьлуулсан ба түр цэгүүдийг арчлах гэрээг нутгийн 2 иргэнтэй байгуулсан.
- Төслийн талбайд бүх нийтийн цэвэрлэгээг Ням гараг бүрт зохион байгуулж хэвшсэн. Цэвэрлэгээг үр дүнтэй байлгах зорилгоор бүх аж ахуйн нэгжүүдэд талбайг хуваарилан өгч, цэвэрлэгээний дараа ерөнхий гүйцэтгэгчээс хяналт тавьж хангалтгүй цэвэрлэсэн тохиолдолд дахин цэвэрлүүлдэг.



- Төслийн ажилтнуудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хаях, түүнийг ач холбогдлыг ойлгуулах, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор хог хаягдал ашиглан бүтээл хийх уралдааныг зарлаж, уралдаанд 13 бүтээл ирсэн. Шилдэг бүтээлээр хаягдал төмөр ашиглан хийсэн генераторын асгаралтын тосгуур шалгарч төслийн талбайд ажиллаж байгаа генераторуудад уг тосгуурыг суурилуулсан.



Зураг 26. Хуванцрыг пресслэсэн байдал



Зураг 27. Бүх нийтийн цэвэрлэгээ хийх талбайн хуваарь

|   |  |   |
|---|--|---|
| <p>хийж суурилуулсан</p> <p><b>АШИГ ТУС</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Талбай хооронд зөвөрлөх боломжтой.</li> <li>-Тос болон түлшний асгаралтыг тосгуурт хадгалах боломжтой.</li> <li>-Сэрээт ячигч болон Краннар зөвөрлөх боломжтой.</li> <li>-Тосгуурыг аян цэвэрлэх боломжтой</li> </ul> |  |  <p><b>ДАРАА</b></p>                       |
| <p><b>БАГИЙН ГИШҮҮД</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Ганлуурчин Б.Баянсуран 80229</li> <li>-Механик Угсрагч Ж.Багэбанди 80250</li> <li>-Төлбөйр Зохион байгуулагч Д. Балрсайхан 80313</li> <li>-Механик Ахлах Ажилтан Ц. Энхбаяр 80403</li> </ul>  |  |   |
| <p><b>ЭКМ</b> МАД – АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ САЙЖРУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ <b>MCS property</b></p>  |  |   |
| <p>Төсөл: Баянхөндий Төсөл<br/>         Баг: Материал Ложистик / Механик Баг<br/>         Огноо: 2024.03.04<br/>         Сайжруулалт: Генераторын асгаралтын тосгууртай суурь</p>   |  |   |
|  <p><b>Ашигласан хаягдал материал</b></p>   |  <p><b>Ашигласан хаягдал материал</b></p> |  <p><b>Ашигласан хаягдал материал</b></p> |

Зураг 28. Хог хаягдлаар бүтээл хийх уралдаан



**Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

| Хаягдлын эх үүсвэр               | Хог хаягдлын ангилал                    | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Баримтлах стандарт, аргачлал | Тоо хэмжээ  | Хэрэгжүүлсэн арга хэмжээ   | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|----------------------------------|---|---|------------------------------|---|--|---------------------------------|
| Ахуйн гаралтай хатуу хог хаягдал | Уурхайн тосгон, оффис, аж ахуйн барилга | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах сургалтын материал бэлтгэж, сургалт зохион байгуулах | Хагас жилд 1 удаа            | Хог хаягдлын тухай хууль 2017. “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт” | Төслийн талбарыг тогтмол цэвэр байлгах, ажилтнуудад хог хаягдлыг ангилан хаяж хэвших дадалтай болгох зорилгоор “Хог хаягдлын менежмент” “Хог хаягдал ангилан ялгалт”, “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах нь” гэсэн 3 агуулгаар сургалтын материал бэлтгэн сургалтуудыг 02, 03, 06 дугаар саруудад зохион байгуулсан. Төслийн ажилтнуудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хаях, түүний ач холбогдлыг ойлгуулах, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор хог хаягдал ашиглан бүтээл хийх уралдааныг зарлаж, уралдаанд 13 бүтээл ирсэн. Генераторын тосгуур, арматураар хийсэн конус, краны конус тогтоогч гэх мэт үр дүнтэй бүтээлүүдийг төслийн талбарт байршуулан, тогтмол ашиглаж байна. | 2,800                           |
|                                  |   | Хог хаягдлыг ангилан, зөвшөөрөгдсөн цэгт хадгалах   | Үйл ажиллагааны туршид       | Хог хаягдлын тухай хууль 2017.  | Төслийн үйл ажиллагаанаас ялгарч байгаа хог хаягдлыг компанийн гүйцэтгэх захирлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан “OHS.EM.604 Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журам”-д заагдсны дагуу ахуйн, дахин ашиглагдах /хуванцар сав, гялгар уут, мод, төмөр/, хаягдал цаас, хоолны үлдэгдэл болон аюултай хог хаягдал гэж ангилан хог хаягдлын цэгт ангилалт тус бүрээр хадгалдаг. Шинэжинст сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж сар бүр 2 сая төгрөгийн хураамжийг төлдөг.   | 14,000                          |
|                                  |   | Энгийн хог хаягдлыг сумын төвийн хогийн цэгт нийлүүлэх  | Хоёр сар тутамд 1 удаа       | Шинэжинст сумын ЗДТГазартай   | Шинэжинст сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй байгуулах хог хаягдлын гэрээг 6 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу энгийн хог хаягдлыг төвлөрсөн цэгт хүргэх   | 43,490                          |

|                                   |                       |   |                     |  |   |       |
|-----------------------------------|-----------------------|---|---------------------|--|---|-------|
|                                   |                       |   |                     | байгуулсан гэрээ   | ажлыг Шинэжинст сумын Диваажингийн үнсэлт ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.<br>Тээврийн зам дагуу Баацагаан сумын Бунхан сайр, Шинэжинст сумын Үзүүр худаг гэх газруудад түр зогсоолыг шинээр байгуулсан. Түр зогсоолд энгийн болон хуванцар хаягдлыг ангилан хаях хогийн савнууд, стандартын шаардлага хангасан зөөврийн 00 суурилуулсан ба түр цэгүүдийг арчлах гэрээг нутгийн 2 иргэнтэй байгуулсан.<br><i>Хавсралт 26. Диваажингийн үнсэлт ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын тайлан</i>  |       |
| Ахуйн гаралтай шингэн хог хаягдал | Уурхайн тосгон, оффис | “Ус хэмнэх аян” зохион байгуулах  | 2024 оны II улиралд | Усны тухай хууль   | Төслийн талбайн ажилтнууд, аж ахуйн нэгжүүдийг усны нөөцийг хэмнэлттэй хэрэглэх, бохирдлоос сэргийлэх, бодитой арга хэмжээг хэрэгжүүлэн, байгаль дэлхийгээ хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулахад дэмжлэг үзүүлэх. Усны нөөцийг хэмнэлттэй хэрэглэдэг, зөв дадал хандлагыг түгээн дэлгэрүүлэх, шилдэг шийдлүүдийг таниулан сурталчилах зорилготой “Усаа хэмнэе” аян 5 дугаар сарын 10-ний өдрөөс 6 дугаар сарын 25-ны хооронд зохион байгуулсан. Аяны хүрээнд ажилтнуудын дунд эссэ бичлэгийн уралдаан зарлаж, шилдгээр шалгарсан оролцогч нарт гарын бэлэг гардуулсан.<br><i>Хавсралт 27. Аяны тайлан</i> | 0,855 |
| Аюултай хог хаягдал               | Эмнэлэг               | Эмнэлгийн аюултай хог хаягдлыг зааврын дагуу хадгалан, Шинэжинст сумын эмнэлэгт нийлүүлэх | 2024 он             | Хог хаягдлын тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/505 тушаал, Шинэжинст сумын Хүн эмнэлэгтэй байгуулсан хог хаягдал нийлүүлэх гэрээ 2023 | Яаралтай тусламжийн төвд эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын саванд хадгалан Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвтэй 2023 оны 12 дугаа сарын 05-ны өдөр байгуулсан “Эмнэлгийн тусгай хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох гэрээ”-ний дагуу Шинэжинст сумын хүн эмнэлэгт 5 удаагийн нийлүүлэлтээр нийт 19.8 кг хог хаягдлыг хүлээлгэн өгсөн.   | 1,606 |

|                           |   |   |  |  |  |   |
|---------------------------|---|---|--|--|--|---|
|                           | Машин механизмын засварын цэг барьж, ашиглалтад орсны дараа | Шингэн тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалан, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх  | 2024 он  | Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг 23-р зүйл | Захиалагч Эрдэнэ Монгол ХХК нь “Хай Би Ойл” ХХК-тай “Аюултай хог хаягдал хүлээн авч тээвэрлэх гэрээ”-г 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан. Барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгч М-Си-Эс Проперти ХХК “Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ”-г 2024 оны 1 дүгээр сарын 01-нд “Элемент” ХХК-тай байгуулсан ба гэрээний дагуу барилгын үйл ажиллагаатай холбоотой үүсч байгаа аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэн устгуулах зохион байгуулалтыг хийдэг. Барилга угсралтын үйл ажиллагаанаас өөр аюултай хог хаягдал үүссэн тохиолдол байхгүй. | - |
|                           |   | Тосоор бохирдсон арчих материал зэрэг аюултай хог хаягдлыг зориулалтын цэгт хадгалах, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид нийлүүлэх | 2024 он  | Хог хаягдлын тухай хууль 2017.                 | “М-Си-Эс Проперти” ХХК тосоор бохирдсон арчих материал буюу аюултай хог хаягдлыг хог хаягдлын цэг дэх аюултай хог хаягдал хадгалах хэсэгт хуримтлуулж 2024 оны 3 болон 4 дүгээр саруудад “Элемент” ХХК-д аюултай хог хаягдал нийлүүлэн устгуулсан.   |   |
| Мэдээллийн сан бүрдүүлэлт | Ялгаруулж буй хог хаягдлыг өдөр бүр ангилан бүртгэх         |   | Хог хаягдлын тухай хууль 2017. 11 дүгээр зүйл, | -  | Төслийн үйл ажиллагаанаас ялгарч байгаа хог хаягдлыг органик, органик биш, дахин ашиглагдах гэсэн ангиллаар өдөр тутам бүртгэдэг. Тайлант хугацаанд 17.3 тн органик биш, 22.1 тн органик, 23.8 тн дахин ашиглагдах, 2.3 тн үнс ялгаруулсан.  | - |

#### **4.15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, дүйцүүлэн хамгаалах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК хүлээсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байдаг.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.4, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.7 заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад “Эрдэнэ Монгол” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон байгалийн бүрдэл тус бүрээр орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-г тусгагдсан.

Баянхөндий төслийн 2024 онд хэрэгжүүлэх ОХШХ-ийг хэрэгжүүлэхэд 4,7 сая төгрөг зарцуулсан.

**Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт  | Хяналтын цэгийн байршил                        | Давтамжийн тоо | Баримтласан стандарт, аргачлал   | Хэрэгжилт  | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) |
|---|--|----------------|--|--|---------------------------------|
| <b>ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙ</b>   |  |                |  |  |                                 |
| Хөрсний чанар - Хими, физикийн үзүүлэлтүүдийг шинжлүүлэх  | Уурхайн барилга байгууламжуудын талбайн орчимд | 6 цэг          | MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ<br>Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 2305:1994   | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хөрсний өнгөн хэсэг дэх хүнд металлын агууламжийг тодорхойлох дээжийг 6 цэг, химийн задлан шинжилгээ, механик бүрэлдэхүүний шинжилгээг барилгын талбайд 5 цэг сонгон авч “Инженер геодези” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид төлөвлөгөөний дагуу 2 удаа хийлгэсэн. Хөрсний дээжинд хийлгэсэн шинжилгээний дүнгээр зарим хүнцлийн агууламж стандартаас давсан үзүүлэлттэй байна.<br><i>Хавсралт 28. Хөрсний шинжилгээний хариу</i> | 0,645                           |
| <b>УУР АМЬСГАЛ</b>  |  |                |  |  |                                 |
| Цаг уур (агаарын хэм, салхины хурд, чиглэл, харьцангуй чийгшил, даралт, бороо цас, ууршилт, нарны цацрагжилт) | Төслийн талбай                                 | Тогтмол        | Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар ШЗ.П.01.03.2014 (Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар XIV дэвтэр. Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур орчны шинжилгээний газар) | Барилга угсралтын талбайд өдөр бүр салхины хурд, температур, агаарын харьцангуй чийгшлийг хэмждэг. Салхины хурд 12 м/сек-ээс дээш гарсан тохиолдолд өргөлтийн ажлыг, 20 м/сек-ээс дээш гарсан тохиолдолд барилга угсралтын үйл ажиллагааг зогсоодог.<br><i>Хавсралт 29. Хэмжилтийн бүртгэл</i>   | -                               |
| Шатахууны хэрэглээг бүртгэх   | Тээрийн хэрэгслүүд                             | Сард 1 удаа    | MNS ISO 14064-1-2015. Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг   | Төслийн талбайд 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 21.5 тн шатахуун, 228.0 тн дизель түлш хэрэглэсэн.   | -                               |
| Нүүрсний хэрэглээг бүртгэх  | Түр кэмп                                       | Сард 1 удаа    |  | Хээрийн ангийн гэрүүдийг нүүрсээр галлан халаадаг, 6.1 тн нүүрс түлсэн.  | Үйл ажиллагааны зардал          |



|   |   |                         | тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж  |   |                        |
|---|---|-------------------------|---|---|------------------------|
| <b>АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>   |   |                         |   |   |                        |
| Суурин станцаар: Агаар дахь том болон жижиг ширхэглэгт тоосонцор                                    | Тусгай зөвшөөрлийн талбайн зүүн урд, хойд зах | Тогтмол                 | MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага  | Агаар дахь тоосонцорын байгалийн горимыг ажиглахаар тусгай зөвшөөрлийн талбайн баруун хойд захад, төслийн үйл ажилланаас үүсэх тоосжилтыг хэмжихээр тусгай зөвшөөрлийн талбайн зүүн урд захад суурьлуулсан 2 багажаар РМ 2.5 болон РМ 10 тоосонцорыг 24 цагийн турш тасралтгүй хэмжиж байна. Зөөврийн тоос хэмжих багажаар байгуулагдах ил уурхайн дээд, доод талд, барилгын талбай, үндсэн кэмп, замын нөлөөлөл зэргээс үүсэх тоосонцрыг сард 1 удаа хэмждэг. Хэмжилтийн сарын дундаж үр дүнгээр стандартаас давсан тохиолдол бүртгэгдээгүй. Тоосжилтыг багасгах зорилгоор зам, талбайн усалгааг тотмол гүйцэтгэдэг. | Үйл ажиллагааны зардал |
| Нөлөөллийн бүсэд айл өвөлжих тохиолдолд айлын ойр орчимд дуу шуугиан, агаар дахь тоосонцорыг хэмжих | Айлын өвөлжөөний орчим                        | Айл өвөлжсөн тохиолдолд | MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага  | Төслийн талбайн ойр орчимд 2024 онд нутгийн айл өрх нутаглаагүй хэдий ч нөлөөллийн бүсэд бүртгэгдсэн 3 байршилд сард 1 удаа дуу шуугиан, тоосжилтыг зөөврийн багажаар хэмждэг.<br><i>Хавсралт 30. Хэмжилтийн бүртгэл</i>  | Үйл ажиллагааны зардал |
| <b>ГАЗРЫН ДООРХ УС</b>  |   |                         |   |   |                        |
| Усны чанарын шинжилгээ  | Гүн заг, Майхан хүрэн худгууд                 | 2                       | MNS 0900:2018 Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ | Тусгай зөвшөөрлийн талбайн ойролцоох худгуудын усны чанарын шинжилгээг 02 болон 09 дүгээр саруудад Усны газрын Хяналтын төв лаборатори, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээр ундны усны стандартын шаардлага хангахгүй гэсэн үр дүн гарсан.<br><i>Хавсралт 31. Усны шинжилгээний харцу</i>  | 0,928                  |

|   |   |             |   |  |                        |
|---|---|-------------|---|--|------------------------|
|   | Кэмийн болон үйлдвэрийн ус хангамжийн худгууд | 8           | MNS 0900:2018 Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ   | Үйлдвэрийн болон хээрийн ангийн ахуйн хэрэглээний усанд усны чанарын шинжилгээг улиралд 1 удаа Усны газрын Хяналтын төв лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээр цахилгаан дамжуулах чанар, натри, кальци, хлор, сульфат, хатуулаг, усанд ууссан бодис, зэрэг элементүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан.<br><i>Хавсралт 32. Усны шинжилгээний харцу</i>   | 1,856                  |
| Тусгай зөвшөөрлийн талбайн 25 км радиус доторх малчдын худгуудад усны түвшний хэмжилт                                 | Сонгосон худгууд                              | Сард 1 удаа | "Эрдэнэ"-ийн бодлого журмын гарын авлага  | Тусгай зөвшөөрлийн талбайн ойролцоох 7 худгийн усны түвшний хэмжилтийг сар бүрийн 28-ны өдөр хийдэг. Хэмжилтийн үр дүнгээр усны түвшний өөрчлөлт ажиглагдаагүй.<br><i>Хавсралт 33. Хэмжилт хийсэн худгуудын байршлын зураг</i>   | Үйл ажиллагааны зардал |
| <b>УРГАМЛАН НӨМРӨГ</b>  |   |             |   |  |                        |
| 10x10 м талбай дахь ургамлын зүйлийн бүрдэл, ургамлын тусгаг бүрхэц, арви, 1x1 м талбайгаас газрын дээрх биомасс авах | БОННУ-нд заагдсан 9 цэгт                      | 1 удаа      | Тухайн бүлгэмдэлд ургаж байгаа ургамлын зүйлийн баялагийг тодорхойлох; Ургамлын зүйлүүдийн (элбэгшил-abundance) арвийг Drude's scale-ээр үнэлэх; 10x10 м талбайн ургамал, хагд, халцгай газар гэх мэт газрын бүрхцийг Браун-Бланке-ийн аргаар нүдэн баримжаагаар үнэлэх; 1x1 м талбай байгуулан ургамлын газрын дээрх биомассын дээж авч, ургамлын бүрхцийг (Раменский, 1938) үнэлэх; | Мониторингийн судалгааг 9 цэгт гүйцэтгэсэн ба 1 болон 9-р цэгүүд уурхайн барилгын талбайн гадна байгаа боловч нөлөөлөлд өртөж ургамлан бүрхэвч цөөрсөн. Ус хангамжийн талбайн 30 хувьд хүрэхүйц тархан ургасан, 4, 5-р цэгт сибирь хармаг ургасан, 6-8-р цэгүүдэд хатсан заг, бударгана, шар хотир, улаан бударгана сэргэсэн. Энэ онд өмнөх жилүүдтэй харьцуулахад унасан хур тунадасны хэмжээ их байсан тул ургамлын биомасс харьцангуй нэмэгдсэн, зүйлийн бүрэлдэхүүн олон байгаа нь судалгааны явцад ажиглагдав.<br><i>Хавсралт 34. Судалгааны үр дүн</i> | Үйл ажиллагааны зардал |

|   |   |                                 |   |  |                        |
|---|---|---------------------------------|---|--|------------------------|
|   |   |                                 | 2019 оны ургамлан нөмрөгийн хээрийн судалгааны үр дүн                         |  |                        |
| Талбай дахь ургамлуудыг бүртгэх   | Газар хөндөх зөвшөөрөл олгох бүрт                           | Зөвшөөрөл хүсэх бүрт            | Ургамалын бичиглэл хийх аргачлал  | Газар хөндөх зөвшөөрөл олгосон тухай бүрт ажил эхлэхийн өмнө тухайн талбай дахь ургамлуудыг бүртгэдэг. Ургамлын бүртгэлээр нэн ховор болон ховор, төслийн талбайд өмнө нь бүртгэгдээгүй ургамал нэмж бүртгэгдээгүй.  | Үйл ажиллагааны зардал |
| <b>АМЬТНЫ АЙМАГ</b>   |   |                                 |   |  |                        |
| Төслийн талбайд тохиолдох мөлхөгч, шувуу, хөхтний зүйлийн бүрдэл, тохиолдсон бодгалийн тоо, байршил | Төслийн талбайд   | 2024 он                         | Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025                                      | Төслийн талбай дотор болон ойр орчимд, худгуудын усны түвшний хэмжилт хийх замд амьтан харагдах бүрт бүртгэдэг, 2024 онд мөлхөгч 3 зүйл, шувуу 22 зүйл, хөхтөн 4 зүйл амьтан нийт 1203 бодгаль бүртгэгдсэн.<br><i>Хавсралт 35. 2024 онд амтван бүртгэгдсэн байрллын зураг</i>  | -                      |
| Жороо тоодог (Chlamydotis undulata) бүртгэгдсэн цэгийн орчимд ажиглалт хийх                         | БОННУ-д заасан цэгүүдэд                                     | 04, 08 сард                     | Монгол орны шувууны Улаан данс, 2011 болон шувуу судлаачдын судалгааны бүтээл | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны (2024 он) дагуу 4, 8 дугаар саруудад Жороо тоодог (Chlamydotis undulata) шувууны нарийвчилсан хайгуул судалгааны ажлыг зохион байгуулан ажилласан боловч бидний хээрийн судалгаагаар Жороо тоодог (Chlamydotis undulata) шувуу судалгааны талбайд тэмдэглэгдээгүй.<br><i>Хавсралт 36. Жороо тоодог шувуу ажигласан судалгааны тайлан</i> | -                      |
| Хөдөлгөөн мэдрэгч камер суурилуулах   | Төслийн талбай, түүний орчмын тохиолдож болох амьдрах орчин | 2024 оны 04 дүгээр сараас эхлэн | Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025                                      | Төслийн талбайтай хамгийн ойр, олон амьтан бүртгэгдэх магадлалтай Босгын сайранд хөдөлгөөн мэдрэгч камерыг суурилуулан ажиглалт хийсэн. Салхи, мал амьтан шөргөөх зэргээр камерын ажиглалтыг тогтмол хийхэд хүндрэл учирсан учир уг хөдөлгөөн мэдрэгч камерыг шилжүүлж байгалийн ургамал үржүүлгийн талбайд суулгасан. Камерт  | 1,074                  |

|   |               |                               |   |  |                        |
|---|---------------|-------------------------------|---|--|------------------------|
|   |               |                               |   | <p>шувуу идэж байгаа муурны дүрс бичигдсэнээс өөр амьтны дүрс бичигдээгүй.</p> <p>Шинэжинст сумын Цагаан хаалганд хөдөлгөөн мэдрэгч 2 ш камерыг суурилуулан, суманд хүлээлгэн өгсөн.</p>   |                        |
| <b>ХАМТЫН ОРОЛЦООТОЙ МОНИТОРИНГ</b>   |               |                               |   |  |                        |
